



# МОНГОЛ УЛСЫН

## ЭДИЙН ЗАСГИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ

ХОЁР ТОМ ГҮРНИЙ ДУНД ОРШИХ  
АРВИН БАЯЛАГ БҮХИЙ ОРОН

Маттиас Хелблэ, Хал Хилл, Деклан Магий

2020 оны 6 дугаар сар





# МОНГОЛ УЛСЫН

## ЭДИЙН ЗАСГИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ

ХОЁР ТОМ ГҮРНИЙ ДУНД ОРШИХ  
АРВИН БАЯЛАГ БҮХИЙ ОРОН

Маттиас Хелблэ, Хал Хилл, Деклан Магий

---

2020 оны 6 дугаар сар



Creative Commons Attribution 3.0 IGO license (CC BY 3.0 IGO)

© 2020 Азийн Хөгжлийн Банк

6 АХБ өргөн чөлөө, Мандалуён хот, 1550 Метро Манила, Филиппин улс

Утас +63 2 8632 4444; Факс +63 2 8636 2444

[www.adb.org](http://www.adb.org)

Зарим эрхийг хуулиар хамгаалсан. 2020 онд хэвлэв.

ISBN 978-92-9262-248-0 (хэвлэмэл), 978-92-9262-249-7 (цахим), 978-92-9262-250-3 (ebook)

Хэвлэлийн дугаар. SGP200172-2

DOI: <http://dx.doi.org/10.22617/SGP200172-2>

Энэхүү хэвлэлд илэрхийлсэн үзэл бодол нь зохиогчийнх бөгөөд Азийн хөгжлийн банк (АХБ), түүний Захирлуудын зөвлөлийн гишүүд болон тэдний төлөөлдөг улсын Засгийн газрын үзэл баримтлал, бодлогыг төлөөлөхгүй болно.

Энэхүү хэвлэлд ашиглагдсан баримт өгөгдлийн үнэн зөвийг АХБ баталгаажуулахгүй бөгөөд тэдгээрийг ашигласны улмаас гарах аливаа үр дагаварт ямар нэгэн хариуцлага хүлээхгүй. Тодорхой компани эсвэл бүтээгдэхүүний тухай дурьдсан нь дурьдагдаагүй бусад ижил төрлийн компани ба бүтээгдэхүүнээс тэдгээрийг илүүд үзэж сурталчлах буюу санал болгох утга агуулаагүй болно.

Аливаа нэг улс орон эсвэл газар зүйн бүс нутгийг энэхүү хэвлэлд дурьдсан буюу нэрлэсэн, эсвэл “улс” гэсэн нэршлийг ашигласнаар, АХБ тухайн улс орон, бүс нутгийн хууль эрх зүйн болон бусад байдлын тухайд ямар нэгэн дүгнэлт, байр суурь илэрхийлээгүй болно.

Энэ хэвлэх ажлыг Creative Commons Attribution 3.0 IGO license (CC BY 3.0 IGO) <https://creativecommons.org/licenses/by/3.0/igo/> лицензийн хүрээнд хийсэн болно. Энэхүү хэвлэлийг ашигласнаар та энэ лицензийн нөхцөлийг мөрдөн баримтлах үүргийг хүлээн зөвшөөрнө. Эх сурвалжийг олж тогтоох, орчуулах, хялбаршуулан хэрэглэх, зөвшөөрөл авах бол <https://www.adb.org/terms-use#openaccess> холбоосоор орж нөхцөл журамтай танилцана уу.

Энэхүү СС лиценз нь тус хэвлэлд дурдагдсан АХБ-ны бус зохиогчийн эрхтэй материалд үл хамаарна. Хэрэв аливаа материал өөр эх сурвалжтай холбоотой бол түүнийг дахин хэвлэх, хуулбарлах зөвшөөрлийг тухайн эх сурвалж бүхий зохиогчийн эрхийн эзэмшигч эсвэл хэвлэгч нарт хандан авна уу. Тухайн материалыг ашигласны улмаас гарах аливаа гомдол шаардлагыг АХБ үл хариуцна.

Хэрэв танд агуулгын талаар асуух зүйл эсвэл санал байгаа бол, эсвэл та эдгээр нөхцөлөөс бусад зорилгоор ашиглахын тулд зохиогчийн эрхийн зөвшөөрөл авахыг хүсвэл, эсвэл АХБ-ны лого тэмдгийг ашиглах зөвшөөрөл хүсэх тохиолдолд [pubsmarketing@adb.org](mailto:pubsmarketing@adb.org) гэсэн хаягаар холбогдоно уу.

АХБ-ны хэвлэлийн залруулгыг дараах хаягаар үзнэ үү: <http://www.adb.org/publications/corrigenda>.

Тайлбар:

Энэхүү нийтлэлд гарах “\$” тэмдэгт нь америк долларыг илэрхийлнэ.

Хавтсан дээрх зургуудыг (Зүүн дээд өнцгөөс эхлэн цагийн зүүний дагуу):

“Сермсанг-Хөшигийн Хөндий” нарны цахилгаан станцын зураг – Ариэл Жавеллана; Монгол Улсын Их Сургуулийн Генетикийн инженерчилэлийн лабораторийн зураг – Эрик Сэйлс; Сайншандын Ерөнхий боловсролын II сургуулийн зураг – Кэвин Хамдорф; Говийн ноолуурын үйлдвэрлэлийн зураг – Хишигдоржийн Цогтбаатар; Фермерүүд өвс бэлтгэж буй зураг – Эрик Сэйлс; Дундговь аймаг дахь нүүрсний уурхайн зураг – Маттиас Хелблэ.

Энэхүү хэвлэл нь **“МОНГОЛ УЛСЫН  
ЭДИЙН ЗАСГИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ:  
ХОЁР ТОМ ГҮРНИЙ ДУНД ОРШИХ  
АРВИН БАЯЛАГ БҮХИЙ ОРОН”**

номны зөвхөн Нэгдүгээр бүлгийн орчуулга болно. Номны англи хувилбарыг бүрэн эхээр нь дараах холбоосоор уншина уу.

[https://www.adb.org/publications/  
mongolia-economic-prospects](https://www.adb.org/publications/mongolia-economic-prospects)

# Агуулга

<b>Хүснэгт ба зураг</b>	<b>v</b>
<b>Өмнөх үг</b>	<b>vi</b>
<b>Талархал</b>	<b>x</b>
<b>Зохиогчдын намтар</b>	<b>xii</b>
<b>Товчилсон үгс</b>	<b>xvii</b>
<b>1. Эдийн засаг: Тойм</b>	<b>1</b>
1.1 Эдийн засгийн тойм	3
1.2 Эдийн засгийн гүйцэтгэл	14
1.3 Дүгнэлт ба бодлогын зөвлөмж	39
<b>Ашигласан материал</b>	<b>49</b>

# Хүснэгт ба зураг

## Хүснэгт

1.1	Монгол, Казахстан, Бүгд Найрамдах Киргиз Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн, 2017 он	17
1.2	Монгол, Казахстан, Бүгд Найрамдах Киргиз Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын засаглалын үзүүлэлтүүд, 2000 ба 2017 он	18
1.3	Монгол, Казахстан, Бүгд Найрамдах Киргиз Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын микро эдийн засгийн үзүүлэлтүүд, 2018 он	19
1.4	Төлбөрийн тэнцэл, 1995, 2010, 2017 он	33
1.5	Монгол, Казахстан, Бүгд Найрамдах Киргиз Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд, 1990 он	36
1.6	Монгол, Казахстан, Бүгд Найрамдах Киргиз Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд, 2017 он	37

## Зураг

1.1	Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт ба нэг хүнд ногдох бодит ДНБ, 1991–2017 он	15
1.2	Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, голлох эх үүсвэрээр, 1971–2015 он	16
1.3	Хөдөө аж ахуй, аж үйлдвэр болон үйлчилгээний салбарын өсөлт, 1991–2017 он	20
1.4	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх салбаруудын хувь хэмжээ, 1991–2017 он	23
1.5	Хөрөнгө оруулалт ба хуримтлал, 1991–2017 он	24
1.6	Инфляци ба валютын ханш, 1991–2017 он	26
1.7	Нэрлэсэн болон бодит үйлчилж буй валютын ханш, 2000–2018 он	27
1.8	Улсын төсвийн болон гадаад төлбөрийн урсгал дансны тэнцэл, 1991–2017 он	28
1.9	Гадаад, дотоод өр, 1997–2017 он	29
1.10	Бараа, үйлчилгээний экспорт, 1996–2018 он	34
1.11	Гадаадын шууд хөрөнгө оруулалт ба хөгжлийн албан ёсны тусламж, 2001–2017 он	35
1.12	Ядуурал ба тэгш бус байдлын үзүүлэлт, 1991–2017 он	38

## ӨМНӨХ ҮГ

Монгол Улс нь өнөөгийн бидний амьдарч буй ертөнцийг төлөвшүүлэхэд асар их хувь нэмэр оруулсан, арвин түүхтэй улс юм. Хөрш хоёр их гүрэнтэйгээ харилцан ашигтай харилцаа тогтооход өөрийн авхаалж самбаа, дасан зохицох уян хатан чадвараа дайчилж, ардчилал, зах зээлийн эдийн засагт сэтгэл шулуудан хөл тавьсан нь тус улсын саяхны бахдам түүх юм. Дэлхий нийтээр коронавирус (КОВИД-19) цар тахалтай нүүр тулсан өнөө үед Монголчууд энэхүү авхаалж самбаа, дасан зохицох чадвар болоод эрэмгий зоригоо илтгэн харуулж, КОВИД-19 цар тахлын эсрэг шийдэмгий хариу арга хэмжээ авч, холбогдох стратегийг хэрэгжүүлэхдээ эдгээр шинж чанаруудаа улам тодоор үлгэрлэн харуулж байна. Гэвч өнөөг хүртэл халдварын тархалтыг тогтоон барьж чадсан хэдий ч, бусад олон орны нэгэн адилаар Монгол Улс нь эмзэг хэвээр байна.

Монгол Улсын эдийн засаг сүүлийн 30 жилд үсрэнгүй хөгжсөн. Тухайлбал, 2000 оноос хойш нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн бодитоор 3 дахин өссөн. Гэсэн хэдий ч тус улсын эдийн засаг тууштай өсөхөөсөө илүү суурь эмзэг байдлыг илтгэх агшилт-тэлэлтийн олон мөчлөгөөр явж ирсэн байна. Тус улсын байгалийн баялгийн салбар нь өсөлтийн томоохон хэсгийг бүрдүүлэхээс гадна өсөлтийн савлагааг үүсгэгч хүчин зүйл болдог гэж үздэг. Түүхий эдийн бүтээгдэхүүний үнэ өндөр байх үед эерэг нөлөө арвин байх хэдий ч тэр чинээгээрээ эдийн засгийн тогтворгүй бөгөөд тодорхойгүй байдал улам бүр нэмэгдэж байдаг. Монгол Улс энэхүү тогтворгүй байдлыг удирдахад баримтлах стратегийнхаа хүрээнд эдийн засгаа төрөлжүүлэхийг хичээн ажиллаж байна. Гэвч эдийн засгийг богино хугацаанд төрөлжүүлэх боломжгүй бөгөөд энэ нь олон арван жилийн туршид ул суурьтай боловсруулсан, жинтэй бодлого хэрэгжүүлэхийг шаарддаг урт хугацааны үйл явц юм.

Энэхүү судалгаанд 1990-ээд оны эхээр Монгол Улсын эдийн засаг, улс төрийн шилжилт хийснээс хойшхи хөгжлийн явцыг эргэн дүгнэсэн бөгөөд шилжилтийн эхэн үеийн хүнд он жилүүдийг хэрхэн амжилттай даван туулж, зах зээлийн тогтолцоонд эдийн засгаа хэрхэн дахин босгож чадсаныг



өгүүлсэн болно. Монгол Улс дэлхийн худалдааны байгууллагад элсэж, уул уурхайн салбарт гадаадын томоохон хөрөнгө оруулалтыг татсан нь нээлттэй эдийн засгийн давуу талыг эрт олж харсан болохыг харуулж байна. Мөн Монгол Улс нь идэвхтэй иргэний нийгэм, чөлөөт хэвлэл бүхий, ардчиллыг бэхжүүлсэн улс болж хөгжсөн. Гэсэн хэдий ч бусад улс орны адилаар олон бэрхшээлтэй тулгарсан хэвээр байна.

2017 онд батлагдсан Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх Түншлэлийн Стратеги нь эрүүл мэнд, боловсрол, эдийн засгийн шинэчлэл, тээвэр, хот байгуулалт, бүс нутгийн хамтын ажиллагаа, байгаль орчны тогтвортой байдлын чиглэлээр АХБ-ны Монголд хуримтлуулсан туршлагад түшиглэж, засаглалыг бэхжүүлэх, жендэрийн тэгш байдлыг сайжруулахад онцгой анхаарсан ач холбогдол өндөртэй стратеги болсон. Энэхүү улс орны оношилгоо судалгааны бүтээл нь 2021 онд батлагдах АХБ-ны Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх дараагийн Түншлэлийн Стратегийн өмнөтгөл болон хэвлэгдэж байгаа юм. Тиймээс уг судалгаа нь тулгарч буй бодлогын гол бэрхшээлүүдийг тодорхойлж, шийдвэрлэх гарцуудыг тоймлоход чиглэгдсэн. Энэхүү судалгаа нь улс орны хөгжлийг хойш татаж буй саад бэрхшээлийг хэрхэн үр дүнтэй даван туулах талаар бодлого боловсруулагчдад шинэ, стратегийн сэдэл өгнө хэмээн бид найдаж байна. Түүнчлэн тус улсын гол салбарууд болоод тулгарч буй асуудлуудын талаарх хамгийн сүүлийн үеийн энэхүү дүн шинжилгээ нь Монгол Улсын нийт ард иргэд болон тус улсыг сонирхож буй гадаадын иргэдэд хэрэгтэй мэдээлэл болох юм. Уг судалгаанд дараах гол дүгнэлтүүдийг хийсэн болно, үүнд:

Нэгдүгээрт, макро эдийн засгийн бодлогын хувьд түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдсэн савлагааг хязгаарлахад анхаарлаа хандуулах хэрэгтэй. Монгол Улс төсвөө бэхжүүлэх чиглэлд томоохон арга хэмжээ авч эхэлсэн бөгөөд эдийн засгийн өсөлтийг жигдрүүлэхэд туслах шинэ хуулиудыг ч мөн батлаад байна. Цаашид амжилтад хүрэхийн тулд макро эдийн засгийн харилцан нийцтэй бодлогыг тууштай хэрэгжүүлэх ёстой. Мөн энэ төрлийн бодлогын үр өгөөжийг бодитоор хүртэхийн тулд төрийн бусад бодлогуудад макро эдийн засгийн бодлогыг цөм хэсэг болгон тусгаж явах нь зүйтэй.

Хоёрдугаарт, макро эдийн засгийн бодлоготой нягт холбоотой нэг асуудал нь Монгол Улсын байгалийн баялгийн менежмент юм. Засгийн газар цаашид уул уурхайн орлогоо тогтвортой болгож, гадаадын хөрөнгө оруулагчдад итгэл төрүүлэхүйц төсвийн чанд дэглэмийг бий болгох шаардлагатай. Орлогын тодорхой хэсгийг тухайн үеийн өрийн удирдлага, өрийн үйлчилгээний бодлоготой нийцүүлэн байнгын хуримтлалын механизмд төвлөрүүлж байх ёстой. Уул уурхайн салбар Монгол Улсад олон жил өгөөжөө өгсөн хэвээр байх тул салбарын бодлогыг эрчимтэй хэвээр нь хадгалж, холбогдох шинэ

боломжуудыг үргэлж эрэлхийлэх нь зүйтэй. Түүнчлэн уул уурхайн үйл ажиллагааны стандартуудыг тасралтгүй сайжруулах нь зүйтэй.

Гуравдугаарт, Монголын эдийн засаг гадаадын тухайлсан зах зээлүүдэд, тэр дундаа уул уурхайн салбарын инженерийн үйлчилгээний салбарт амжилттай нэвтрээд байна. Монгол Улсын газар зүйн байршлыг хөгжлийг хойш татдаг бул чулуу, сул тал гэж нэрлэж байсан ч, тус улс сүүлийн 30 жилийн турш дэлхийн хамгийн эрчимтэй өсч буй том эдийн засагтай холбогддог. Энэ нь ашиглаж болох шавхагдашгүй эдийн засгийн боломж, боллоцоог бүрдүүлж буй юм. Тиймээс урт хугацааны бүс нутгийн хамтын ажиллагаа, интеграцчиллын стратегийн хүрээнд эдгээр давуу талыг өөрт ашиглах зорилгоор илүү их хүчин чармайлт гаргах шаардлагатай байна. Эдийн засгийг төрөлжүүлэх нь стратегийн чухал хэсэг байх боловч түүнд урт хугацаа шаардагдах нь тодорхой тул түүхий эдийн үнийн хэлбэлзэлд өртөмтгий Монгол Улсын эмзэг байдлыг бууруулж чадахуйц макро эдийн засгийн бодлогыг богино хугацаанд хавсран хэрэгжүүлэх нь зүйтэй. Мөн төрөөс олон улсын худалдааг дэмжих чиглэлд идэвхийлэн ажилласнаар эдийн засгаа амжилттай төрөлжүүлж чадна. Тиймээс экспорт, импортын журмыг цаашид хялбарчлах хэрэгтэй. Олон улсын стандартыг хангахын тулд компаниудыг олон улсын магадлан итгэмжлэгдсэн лабораторийн үйлчилгээ авах боломжоор хангах шаардлагатай. АХБ эдгээр үйл ажиллагааг дэмжиж, хамгийн сүүлд хилийн боомтыг шинэчилж, лабораторийн стандартыг сайжруулах ажлыг хэрэгжүүлж эхэлсэн. Эдгээр хүчин чармайлт нь худалдааг хөнгөвчлөх, том болоод жижиг аж ахуйн нэгжүүдэд гадаад зах зээлд илүү хялбар нэвтрэх боломжийг олгох болно.

Дөрөвдүгээрт, цаашид хөрөнгө оруулалт хийх шаардлагатай чухал нэг чиглэл бол дэд бүтцийн салбар юм. Орчин үеийн тээврийн дэд бүтцийн хэрэгцээ өндөр хэвээр байгаа тул хөрөнгө оруулалт ч мөн ихээр шаардагдаж байна. Иймд Засгийн газар өндөр өгөөжтэй төслүүдийг эрэмбэлэх байдлаар хязгаарлагдмал нөөцөө хуваарилахын зэрэгцээ дэд бүтцэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга замыг эрэлхийлэх шаардлагатай. Мөн эрчим хүчний салбарт цахилгаан хангамжийн найдвартай байдлыг нэмэгдүүлж, эрчим хүч, түүний дотор дулаан үйлдвэрлэх явцад үүсэх бохирдлыг улам бүр бууруулах ёстой.

Эцэст нь, нийслэл рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөн нэмэгдэхийн хэрээр Монголын эдийн засаг үйлчилгээнд суурилсан эдийн засаг руу хөрвөх чиглэлд орж байна. Тиймээс Засгийн газар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд уялдсан, зөв ур чадвартай залуу ажиллах хүчин бэлтгэх замаар энэхүү шилжилтийг дэмжих боломжтой юм. Мөн өнөөгийн КОВИД-19-ийн хямралаас харахад эрүүл мэндийн сайн тогтолцоотой байх нь цэцэглэн

хөгжих нийгмийн үндэс суурь юм. Иймд орон даяар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, түүний хүртээмжийг сайжруулах нь ирээдүйд өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт байх болно.

Монгол Улс байгалийн баялаг ихтэйгийн сацуу авьяаслаг, чадварлаг хүний нөөцтэй улс юм. Бидний уг судалгаа нь Монгол Улсыг дээрх хоёр баялгаа зөв зохистой ашиглаж, үр өгөөжийг нь хүртэх боломжийг олж харахад тусална хэмээн найдаж байна. АХБ нь Монгол Улстай 1991 оноос хамтын ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд түүнээс хойш АХБ болон Монголын ард түмний харилцаа нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн төлөөх хамтын зорилгод суурилсан хүчтэй түншлэл болон хөгжиж иржээ. Бид Монгол Улс болон Монголын ард түмэнтэй үргэлжлүүлэн тууштай хамтран ажилласан хэвээр байх болно.



**Ясуюки Савада**

Ерөнхий эдийн засагч бөгөөд  
Эдийн Засгийн Судалгаа, Бүс  
Нутгийн Хамтын Ажиллагааны  
Газрын дарга, Азийн Хөгжлийн  
Банк



**Жеймс П.Линч**

Зүүн Азийн  
Газрын дарга,  
Азийн хөгжлийн банк

## Талархал

Монгол Улсыг оношлох энэхүү судалгааг Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны “Хөгжиж буй зарим гишүүн орнуудад улс орны оношилгоо судалгаа хийх нь” бүс нутгийн техникийн туслалцааны төсөл (ТА 8343-REG)-ийн хүрээнд бэлтгэсэн болно. Энэхүү судалгааг Эдийн засгийн судалгаа, үйл ажиллагааг дэмжих хэлтэс (ЭЗСҮАДХ)-ийн дарга Рана Хасаны удирдлага дор Эдийн засгийн судалгаа, бүс нутгийн хамтын ажиллагааны газар (ЭЗСБНХАГ)-аас хийсэн болно. ЭЗСҮАДХ, ЭЗСБНХАГ-ын эдийн засагч Маттиас Хелблэ, Австралийн Үндэсний Их Сургуулийн профессор Хал Хилл, АХБ-ны Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газрын Ахлах эдийн засагч Деклан Магий нар энэхүү судалгааны ботийг хамтран хянан тохиолдуулсан болно. Салбарын гүнзгийрүүлсэн судалгааг дараах багууд боловсруулсан болно, үүнд: Бүлэг 1 (Монголын эдийн засаг - Тойм)-ийг Хал Хилл, Маттиас Хелблэ; Бүлэг 2 (Макро эдийн засгийн менежмент)-ыг Александр Леманн, Жункю Ли нар; Бүлэг 3 (Байгалийн арвин нөөцийг удирдах нь)-ыг Намхайжанцангийн Дорждарь, Марсель Шредер; Бүлэг 4 (Уул уурхайгаас гаднах эдийн засгийн төрөлжилт)-ийг Батдэлгэрийн Түвшинтөгс, Чулуунбатын Нарантуяа, Баярцогтын Хорол-Эрдэнэ, Дэлгэрчулууны Анхбаяр; Бүлэг 5 (Олон улсын асуудал: Худалдаа, гадаадын шууд хөрөнгө оруулалт ба хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөн)-ыг Према-чандра Атукорала, Маттиас Хелблэ; Бүлэг 6 (Дэд бүтэц ба бүс нутгийн зах зээлтэй холбогдсон байдал)-г Ричард Помфрет; Бүлэг 7 (Институци ба засаглал)-г Далайбуяны Бямбажав, Жулиан Диеркес; Бүлэг 8 (Нийгмийн хөгжил, амьжиргааны түвшин ба хөдөлмөрийн зах зээл)-ыг Баяржаргалын Ариун, Хайди Эр-Дупуй нар тус тус боловсруулсан болно. Жилл Гейл де Вилла, Аластаир Макиндо нар туслах редактораар ажиллав. Мариа Ровена Чам, Орли Веларде, Жий Анн Кэрол Бурак нар судалгаа, захиргаа болон техникийн ерөнхий дэмжлэг үзүүлсэн болно. Амадор Форонда, Жед Франциско нар судалгааны туслалцаа үзүүлсэн бол Майк Кортес график дизайныг хийж, бичвэрийн форматыг тохируулсан болно.

Энэхүү судалгаа нь Монгол Улсын Засгийн газрын гол яамдууд, түүний харьяа бодлогын судалгааны байгууллага болон эрдэм шинжилгээний байгууллагуудтай хийсэн өргөн хүрээний зөвлөгөөний үр дүнд бүтээгдсэн

юм. Судалгааны баг үнэлж баршгүй зөвлөгөө өгсөн дараах бүх байгууллагад онцгойлон талархал илэрхийлж байна. Үүнд, Монголбанк; Байгаль орчин, аялал жуулчлалын яам; Сангийн яам; Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам; Эрүүл мэндийн яам; Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам; УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны ажлын алба зэрэг болно. 2019 оны 4-р сард Улаанбаатарт зохион байгуулсан зөвлөлдөх семинарын үеэр оролцсон оролцогчид болон илтгэгчид, ялангуяа үндсэн илтгэгч МУИС-ийн профессор Банзрагчийн Отгонтөгсөөс өгсөн санал, зөвлөмжийг бид өндрөөр үнэлж буй болно. Доктор Баяржаргалын Ариун нь газар дээр уулзалтуудыг зохион байгуулахад гүн туслалцаа үзүүлсэн болно.

Иргэний нийгэм, хөгжлийн түншүүд, төрийн өмчит аж ахуйн нэгжүүд болон хувийн хэвшил зэрэг бусад оролцогч талуудын оруулсан хувь нэмэр судалгаанд чухал үүрэг гүйцэтгэснийг онцлон тэмдэглэж байна. Үнэ цэнэтэй санал, зөвлөмж өгсөн Монголын бизнесийн зөвлөл, Олон улсын валютын сан, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим болон Дэлхийн Банк Группд талархлаа илэрхийлж байна. Мөн МУИС-ийн хамт олонд талархаж байна. Эцэст, АХБ-ны Монгол Улс дахь Суурин төлөөлөгч Павит Рамачандран, өмнөх Суурин төлөөлөгч Ёланда Фернандез Ломмен нараар ахлуулсан төлөөлөгчийн газрын нөхөд болох Сандагдоржийн Болд, Далайхүүгийн Өнөржаргал, Бэгзсүрэнгийн Цолмон, Энхболдын Энэрэлт, Энхбаатарын Батцэрэн, Өлзий-Оршихын Энхцацрал болон Лхагвасүрэнгийн Амар (өмнөх эдийн засагч) нарт гүн туслалцаа үзүүлж, хамтран ажилласанд талархал илэрхийлье.

## Зохиогчдын намтар

**Према-чандра Атукорала** нь Австралийн Үндэсний Их Сургууль (АУИС)-ийн Ази, Номхон далайн коллежийн Арндт-Кордены нэрэмжит эдийн засгийн тэнхимийн эдийн засгийн профессор, Австралийн Нийгмийн шинжлэх ухааны академийн гишүүн, Манчестерийн Их Сургуулийн хүндэт профессор-эрдэмтэн судлаач юм. Тэрээр 10 ном, 6 хянан тохиолдуулсан боть, эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлэгдсэн 116 өгүүлэл, хамтарсан бүтээлийн 79 бүлэг, олон тооны номын шүүмж, бодлогын баримт бичиг, зөвлөх үйлчилгээний тайлангуудыг туурвисан. Тэрээр Азийн эдийн засгийн сэтгүүл, Азийн хөгжлийн тойм болон Ази, Номхон далайн эдийн засгийн бүтээлийн редакцын зөвлөлийн гишүүнээр ажилладаг. Тэрээр Австралийн Олон улсын хөгжлийн агентлаг, Азийн Хөгжлийн Банк (АХБ), Олон улсын хөдөлмөрийн байгууллага, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ) болон НҮБ-ын бусад төрөлжсөн байгууллагууд болон Дэлхийн Банканд зөвлөхөөр ажиллаж байсан туршлагатай. Тэрээр эдгээр байгууллагуудад зөвлөхөөр ажиллахдаа 16 гаруй оронд ажилласан байна.

**Батдэлгэрийн Түвшинтөгс** нь МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэн (ЭЗХ)-гийн захирал, Эдийн засгийн дэд профессор юм. Тэрээр өөрийн оронд явагдах бодлогын хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож, санхүүгийн хямралын Монголын эдийн засагт үзүүлэх нөлөө, стратегийн томоохон уурхайнуудын Монголын эдийн засаг, бизнесийн орчинд үзүүлэх нөлөөг үнэлэх бодлогын шинжилгээний төслүүдийн судалгааны багийг удирддаг. Түүний судалгааны чиглэлүүдэд макро эдийн засаг, мөнгөний эдийн засаг, олон улсын санхүү, Монголын эдийн засаг зэрэг багтана. Тэрээр Бостоны Их Сургуульд эдийн засгийн ухааны докторын зэрэг хамгаалсан бөгөөд өмнө нь Монголбанканд ажиллаж байсан.

**Баяржаргалын Ариун-Эрдэнэ** нь АУИС-ийн Эдийн засгийн судалгааны сургуулийн багш юм. Түүний судалгааны чиглэл нь тэгш бус байдал, хөдөлмөрийн зах зээлийн асуудал, микро эдийн засгийн шинжилгээ юм. Тэрээр Австралийн эцэг эхийн амралтын орлогод үзүүлэх нөлөө болоод Инновацийн төрлийг тодорхойлох хүчин зүйлс зэрэг сэдвийн хүрээнд

судалгааны төслүүд дээр ажиллаж байна. Тэрээр Монгол дахь өрхийн стресс тестийн загвар, ядуурал, тэгш бус байдал, өсөлтийн талаарх судалгааны өгүүллүүдийг хэвлүүлжээ. Мөн тэрээр МУИС-ийн Эдийн засгийн багшаар ажиллаж байсан бөгөөд ЭЗХ, АХБ, Нээлттэй нийгэм хүрээлэн зэрэг үндэсний болон олон улсын байгууллагуудад зөвлөхөөр ажиллаж байсан. Тэрээр Японы София Их Сургуульд Хөгжил судлалын магистрын зэрэг хамгаалсан.

**Далайбуянгийн Бямбажав** нь Монголын Бодлогын инновацийн хүрээлэнгийн захирал юм. Тэрээр төрийн ба хувийн хэвшлийн баялгийн салбар, сайн засаглал, бизнес, нийгмийн харилцаа, компанийн нийгмийн хариуцлага зэрэг хөгжиж буй орнуудын засаглал, тогтвортой байдлын тулгамдсан асуудлуудад чиглэсэн судалгаа хийдэг. Д.Бямбажав нь Квинсландын Их Сургууль, Хоккайдогийн Их Сургууль, Тохоку их сургууль, МУБИС-д эрдэм шинжилгээний ажил хийж, багшилж байсан бөгөөд Хүний эрхийн үндэсний комисс, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, НҮБХХ, Олон Улсын Санхүүгийн Корпораци, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн (NRGI), Канадын Олон Улсын Нөөц ба Хөгжлийн Санаачилга болон Бертелсманн сан зэрэг байгууллагуудад зөвлөх, судлаачаар ажиллаж байсан. Тэрээр Хоккайдогийн Их Сургуульд Улс төрийн социологийн ухааны доктор цол хамгаалсан.

**Жулиан Дьеркес** нь Бритиш Колумбын Их Сургууль (БКИС)-ийн Азийн Судалгааны Хүрээлэн болон Олон нийтийн бодлого, дэлхийн харилцааны сургуулийн дэд профессор юм. Тэрээр тус хүрээлэнгийн Төв Ази дахь хөтөлбөрийн зохицуулагч бөгөөд Монголд олонтоо ирдэг. Тэрээр өнөө цагийн Монголоос гадна ялангуяа Япон дахь албан бус боловсрол, дижитал дипломат бодлогын чиглэлээр түлхүү судалдаг. Тэрээр БКИС-д Монголын уул уурхайн зохицуулалтын чиглэлээр төгсөлтийн дараах сургалтын төслүүдийг удирдаж байсан. Жулиан Дьеркес нь 2017 онд Берлиний Гумбольдтын Их Сургуульд Монголын улс төрийн тухай семинарыг удирдан багшилж байсан бөгөөд Монгол Улсын 2008, 2012 оны УИХ-ын сонгууль, 2009, 2013 болон 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр ажиглагчаар ажиллаж байсан. Тэрээр Ази, Номхон далайн орнуудын мемо, Зүүн Азийн форум, Файнаншиал Таймсын БРИКС-ийн цаадах орнууд, Дипломат, болон бусад сэтгүүлд Монголын талаар бичихийн зэрэгцээ Монгол дахь улс төрийн эрсдлийн талаар зөвлөгөө өгч ажилладаг. Тэрээр социологич мэргэжилтэй бөгөөд Принстоны Их Сургуульд докторын зэрэг хамгаалсан.

**Хайди Эр-Дупуй** нь АХБ-ны Тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийн газар (ТХУАӨГ)-ын (Хөдөлмөрийн суурь хэм хэмжээ хариуцсан) Нийгмийн хөгжлийн ахлах мэргэжилтэн юм. Тэрээр АХБ-ны нийгмийн хамгааллын шаардлагын дагуу хөдөлмөрийн суурь хэм хэмжээг сахиулах үүднээс АХБ-ны

санхүүжилттэй төслүүдэд хяналт тавихад дэмжлэг үзүүлдэг. Тэрээр АХБ-ны санхүүжилттэй төслүүдийн хөдөлмөрийн асуудалтай холбогдолтой харилцааг хянан зохицуулж, АХБ-ны нийгмийн хамгааллын шаардлагуудад нийцэж буй эсэхэд хяналт тавьдаг. Хайди Эр-Дупуй нь АХБ-инд ажиллаж эхлэхээсээ өмнө Дэлхийн Зөн байгууллагын Камбож дахь салбарын Нөлөөлөл, харилцаа холбооны газрын даргаар ажиллаж байсан бөгөөд хүүхэд хамгаалал, хүүхдийн хөдөлмөр, хүн худалдаалах гэмт хэрэг, хүнсний аюулгүй байдал, засаглал, нийгмийн шударга ёсны чиглэлээр ажиллаж байсан туршлагатай. Тэрээр Висконсины Их Сургуулийн Эдийн засаг, Байгаль хамгааллын биологийн чиглэлээр давхар магистрын зэрэг хамгаалсан.

**Маттиас Хелблэ** нь АХБ-ны Эдийн засгийн судалгаа, бүс нутгийн хамтын ажиллагааны газар (ЭЗСБНХА)-ын Эдийн засагч юм. Өмнө нь тэрээр Токио дахь АХБ-ны Хүрээлэнгийн Судалгааны хэлтсийн ахлах судлаач, хамтран даргалагчаар ажиллаж байсан. Тэрээр олон улсын худалдаа, эрүүл мэнд болон орон сууцжуулалтын чиглэлээр судалгаа хийдэг бөгөөд эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд олон тооны өгүүлэл болоод 10 ном хэвлүүлж, олон улсын байгууллагуудын үндсэн тайлан боловсруулахад хувь нэмэр оруулан ажиллаж байсан. Тэрээр Вашингтон хот дахь Дэлхийн Банкнаас карьераа эхлүүлж, дараа нь Женев дэх Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, Дэлхийн Худалдааны Байгууллага болон НҮБ-д эдийн засагчаар ажиллаж байсан. Тэрээр Тюбингений Их Сургууль, Висконсин-Мэдисоны Их Сургуулийн төгсөлтийн дараах хөтөлбөрт сурч, Женев дэх Олон Улсын Хөгжлийн Судалгааны Институтэд докторын зэргээ хамгаалсан. Докторантурт сурч байхдаа Йелийн их сургуульд судлаач эрдэмтнээр ажиллаж байсан.

**Хал Хилл** нь АҮИС-ийн Зүүн-Өмнөд Азийн эдийн засгийн салбарын Х.В. Арндтын нэрэмжит Эмирэтус профессор юм. Тэрээр 20 ном, 170 орчим сэтгүүлийн өгүүлэл болон номын бүлгүүдийг туурвиж/редактораар ажилласан юм. Тэрээр сүүлийн 20 гаруй жил олон чиглэлийн эрдэмтэн, судлаачдаас бүрдэх томоохон судалгааны төслүүдийг идэвхтэй бие даан болон хамтран ахалж, Азийн эдийн засгийн хөгжлийн олон асуудлаар боть номууд гаргасан. Тэрээр Индонезийн эдийн засгийн номынхоо бүрэн шинэчилсэн, гурав дахь хэвлэлийг бэлтгэж буй бөгөөд Кембриджийн их сургуулийн хэвлэлээс тус номыг хэвлэхээр зэхэж буй юм. Хал Хилл нь 10 улсад зочин эрдэмтнээр ажиллаж байсан бөгөөд, олон тооны зөвлөх хорооны гишүүн, засгийн газар болон АХБ зэрэг олон улсын агентлагуудад зөвлөхөөр ажилладаг. Тэрээр Австралийн Нийгмийн Шинжлэх Ухааны Академийн гишүүн бөгөөд Австралийн одонт офицер юм.



**Жункю Ли** нь АХБ-ны ТХУАӨГ-ын Санхүүгийн салбарын бүлгийн дарга юм. Тэрээр олон улсын эдийн засгийн бодлого болон бусад холбогдох чиглэлээр арвин их мэдлэг, туршлагатай бөгөөд сүүлийн жилүүдэд Азийн Эдийн Засгийн Интеграцийн Тайлангийн олон улсын хөрөнгө оруулалтын бодлогын үүрэг болон санхүүгийн даван туулах чадварын талаарх бүлгийн судалгааг удирдсан. Түүний бодлогын судалгааны сэдвүүдэд санхүүгийн тогтвортой байдал ба нийгмийн хамгаалал, чанаргүй хөрөнгө, шийдвэрлэх механизм, бүс нутгийн нийгмийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, санхүүгийн интеграцчилал, макро зохистой бодлого зэрэг багтана. Тэрээр АХБ-нд ажиллахаасаа өмнө “АСЕАН + 3”-ын Макро эдийн засгийн судалгааны албаны зөвлөлдөх зөвлөлийн гишүүн, Их 20-ийн тусгай зөвлөх, 2009-2012 онд БНСУ-ын Сангийн сайдын олон улсын эдийн засгийн зөвлөх, Бүгд Найрамдах Солонгос Улс болон АНУ, Европын Холбооны хоёр талт чөлөөт худалдааны хэлэлцээрийн багийн гишүүн, Солонгосын Олон улсын эдийн засгийн бодлогын хүрээлэнгийн захирлаар тус тус ажиллаж байсан.

**Алекс Леманн** нь Европын хамгийн нэр хүндтэй эдийн засгийн бодлогын судалгааны төв болох Вгуетел-ийн резидент бус судлаач бөгөөд Зүүн Европын хэд хэдэн төв банк, засгийн газарт зөвлөхөөр ажилладаг. Тэрээр 2016 он хүртэл Европын сэргээн босголт, хөгжлийн банкны тэргүүлэх эдийн засагчаар ажиллаж, төв Европ, Балтийн орнуудын стратеги, эдийн засгийн нэгжийг удирдаж байсан. Тэрээр өмнө нь Вашингтон хотод төвтэй Олон улсын валютын сан (ОУВС)-д мэргэжилтэн, Дэлхийн Худалдааны Байгууллага болон Мексикийн төв банканд зөвлөхөөр ажиллаж байсан. Алекс Леманн нь Олон улсын харилцааны хааны институт (Чатам Хаус), Лондонгийн эдийн засгийн сургууль (ЛЭЗС) зэрэгт багшилж, судалгаа хийж байсан бөгөөд худалдаа, өрсөлдөөний бодлого, евро бүс болон шинээр хөгжиж буй улсуудын санхүүгийн бодлогын талаар бүтээл нийтэлж байсан. Тэрээр ЛЭЗС-ийн эдийн засгийн магистр, Оксфордын их сургуулийн докторын зэрэг хамгаалсан.

**Деклан Магий** нь АХБ-ны Монгол Улс дахь Дэд суурин төлөөлөгч бөгөөд улс хариуцсан Ахлах эдийн засагч юм. Тэрээр АХБ-ны Монгол дахь стратеги, хөтөлбөр боловсруулалт, эдийн засгийн шинжилгээ, хандивлагчдын уялдаа зохицуулалт, мөн макро эдийн засаг, статистик болон засаглалын техникийн туслалцааны хэрэгжилтийг хариуцан ажилладаг. Тэрээр өмнө нь Мьянмар улс болон Лондон хотноо Нэгдсэн Вант Улсын Олон улсын хөгжлийн яаманд хүртээмжтэй өсөлт, худалдаа, олон талт үр ашигтай харилцаа, мөн ядуурлыг бууруулж, шийдвэр гаргахад шаардлагатай тоон мэдээллийн боловсруулалтыг хариуцсан хэд хэдэн албан тушаалд ажиллаж байсан. Тэрээр Бурунди улсын Худалдаа, аж үйлдвэрийн яаманд хөгжлийн институцийн судлаачаар ажиллаж байсан бөгөөд ЛЭЗС-д эдийн засгийн магистрын зэрэг хамгаалсан.

**Намхайжанцангийн Дорждарь** нь байгалийн баялаг ихтэй орнуудад газрын тос, байгалийн хий болон уул уурхайн баялгийн өгөөжийг ард иргэдэд хүртээхэд хувь нэмэр оруулах үйл ажиллагаа явуулдаг олон улсын ашгийн бус байгууллага болох ББЗХ-гийн Монгол дахь менежер юм. Тэрээр ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх, уул уурхайн төрийн өмчит байгууллагуудын засаглалыг сайжруулах, мөн татварын бодлого, практик ба уул уурхайн орлогын менежмент, засгийн газрын төсвийн хариуцлагатай удирдлагыг бэхжүүлэх, бие даасан баялгийн сан байгуулах, уул уурхайн гэрээнд дүн шинжилгээ хийх, хяналт тавих зэргээр Монголын динамик уул уурхайн салбарын сайн засаглалыг бэхжүүлэхэд тусгай анхаарал хандуулан ажилладаг. Тэрээр ББЗХ-нд томилогдохоосоо өмнө Монгол дахь Нээлттэй нийгэм форумд ажиллаж байсан бөгөөд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ын Олон улсын зөвлөл, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан. Тэрээр уул уурхайн гэрээний ил тод байдал, дүн шинжилгээ хийх, хэлэлцээр хийх талаар Монгол Улсын Засгийн газарт зөвлөж байсан ба Төв Европын Их Сургуульд эдийн засгийн магистрын зэрэг хамгаалсан.


**Ричард Помфрет** нь Олон улсын худалдааны хүрээлэнгийн Европын интеграцийн эдийн засгийн Жан Моннетийн нэрэмжит захирал бөгөөд 1992 оноос хойш Аделэйдын Их Сургуулийн эдийн засгийн профессороор ажиллаж байна. Тэрээр 1979-1991 онд Жонс Хопкинсийн Их Сургуулийн Олон улсын судлалын сургуулийн эдийн засгийн профессороор ажиллаж байсан. Ричард Помфрет нь АХБ, ОУВС, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ), НҮБ болон Дэлхийн банкны зөвлөхөөр ажиллаж байсан бөгөөд 100 гаруй өгүүлэл, 20 гаруй ном хэвлүүлсэн. Тэрээр Саймон Фрейзерийн Их Сургуульд эдийн засгийн ухааны докторын зэрэг хамгаалсан.

**Марсель Шредер** нь АХБ-ны ЭЗСБНХАГ-ын эдийн засагч юм. Тэрээр АХБ-нд ажиллаж эхлэхээсээ өмнө Ливан дахь Америкийн Их Сургуулийн дэд профессор, АҮИС-ийн Хөгжлийн бодлогын төвийн багшаар ажиллаж байсан. Тэрээр эдийн засгийн хөгжлийн макро эдийн засгийн асуудлууд, тэр дундаа байгалийн баялаг ихтэй хөгжиж буй орнуудын бодлогод чиглэсэн судалгаагаар мэргэшсэн. Тэрээр АҮИС-д Эдийн засгийн ухааны докторын зэрэг хамгаалсан.

## Товчилсон үгс:

АХБ	— Азийн Хөгжлийн Банк
ШӨХТГ	— Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
МБ	— Монголбанк
КАРЕК	— Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр
КОМЕКОН	— Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл
ХБ	— Монгол Улсын Хөгжлийн банк
ОУИТБС	— Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
ГШХО	— Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДНБ	— Дотоодын нийт бүтээгдэхүүн
GIZ	— Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
ӨНЭЗС	— Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
ОУХБ	— Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУВС	— Олон улсын валютын сан
ЭЗТТМЯХХ	— Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээр
км	— километр
БНАЛАУ	— Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс
АХОТ	— ажиллах хүчний оролцооны түвшин
МИАТ	— Монголын Иргэний Агаарын Тээвэр
УИХ-ын гишүүн	— Улсын Их Хурлын гишүүн
МВт	— мегаватт
ЧЗ	— чанаргүй зээл
БНХАУ	— Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ХХХ	— Хөнгөлөлттэй худалдааны хэлэлцээр
БҮН	— Бодит үйлчилж буй ханш
ЖДҮ	— жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид
ТМБС	— техник, мэргэжлийн боловсрол, сургалт
АНУ	— Америкийн Нэгдсэн Улс
АНУ-ын ОУХА	— АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг
НӨАТ	— нэмэгдсэн өртгийн албан татвар
ДХБ	— Дэлхийн Худалдааны Байгууллага

# MONGOLIA



This map was produced by the company, and the user does not need to pay. The copyright © 2023. All rights reserved. The map data is provided by the National Development Bank, and the map data is provided by the National Development Bank. The map data is provided by the National Development Bank.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

# Эдийн засаг: Тойм

*Хал Хилл, Маттиас Хелблэ нар*

Монгол Улс нь бага-дунд орлоготой, далайд гарцгүй, байгалийн баялаг ихтэй, шилжилтийн шатанд яваа нээлттэй эдийн засаг бүхий улс юм. Эдгээр онцлог нь тус улсын баялаг түүхийн хамтаар ойрын жилүүдийнх нь хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж ирсэн бөгөөд эдийн засгийн төлвийг тодорхойлоход голлох нөлөө үзүүлсээр байна.

1980-аад оны сүүлчээр ЗХУ задран унаж, Зөвлөлтийн цэргүүд Монголоос гарахтай зэрэгцэн 1989 оны сүүлээс ардчиллыг шаардсан тайван жагсаал, цуглаан Улаанбаатар хотын Сүхбаатарын талбай болон олон нийтийн цуглралтын бусад томоохон газруудад хүчээ авсан. Улмаар Засгийн газар 1990 оны 3-р сард тус улсын анхны олон намын өрсөлдөөн бүхий сонгуулийг явуулахаар шийдвэрлэж, мөн оны 7-р сард сонгууль явагдсан. Сонгуулийн үр дүнд Монгол Ардын Хувьсгалт Нам ялалт байгуулж, сөрөг хүчний өрсөлдөгчдөө эвслийн засгийн газарт оруулсан.

Улмаар тус улс ардчиллыг хөрсөндөө бат суулгаж, эдийн засгаа “огцом” либералчлахын тулд Зөвлөлтийн бус гуравдагч улстай, тэр дундаа БНХАУ, АНУ-тай харилцаагаа хэвийн болгох замаар эдийн засаг, улс төрийн эрс шинэ стратеги хэрэгжүүлж эхэлсэн. Монгол Улс 1991 онд Азийн Хөгжлийн Банк, Олон улсын валютын сан, Дэлхийн Банк, Дэлхийн Худалдааны Байгууллагад гишүүнээр элсэх хүсэлт гаргаж,<sup>1</sup> барууны хандивлагчдын дэмжлэг авах бодлого хэрэгжүүлж эхэлсэн.

Төвлөрсөн төлөвлөгөөт, коммунист үзэл суртал суурилсан, Зөвлөлт холбоот улсаас хараат эдийн засгийг зах зээлд суурилсан эдийн засаг руу шилжүүлэх явц маш түргэн хугацаанд явагдсан бөгөөд бэлтгэл багатай байсан тул эмх замбараагүй байдал үүсч байсан. Монгол Улс нь ЗХУ-аас хүлээн авдаг

<sup>1</sup> Монгол Улс Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр (ТХЕХ)-т 1991 онд элсэх өргөдөл гаргаж, нэгдэх хэлэлцээр хийсний дараа 1997 онд БНХАУ, ОХУ-аас өмнө Дэлхийн Худалдааны Байгууллагын гишүүн болсон.

байсан их хэмжээний тусламжаар эдийн засаг, амьжиргааны түвшингээ тогтвортой барьж байсан бөгөөд ЗХУ-тай хийх худалдаанд дотоодын нийт бүтээгдэхүүний 30 орчим хувьтай тэнцэх хэмжээний томоохон алдагдал хүлээдэг байсан (Помфрет 2002). Гэвч эрчим хүч, хүнс, түүхий эд, капитал тоног төхөөрөмж болоод зах зээлд нэвтрэх эрх зэргийг хамарсан энэхүү тусламж гэнэт дуусгавар болсон. Улсын бараг бүх өмч, түүний дотор орон сууц, мал зэргийг иргэдэд хувьчилж, ЗХУ-ын үеийн эдийн засагт ноёрхож байсан төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг тогтвортой ажиллуулж байсан татаасыг цуцалсан. Боловсрол, эрүүл мэнд болон тэтгэвэр зэрэг төрөөс үзүүлэх нийгмийн үйлчилгээг эрс багасгасан. Иргэд олноороо мал дээр гарч, амьжиргаагаа залгуулах болсон нь тодорхой хэмжээнд нэмэртэй байсан ч амьжиргааны түвшин огцом унасан. Эмх замбараагүй байдлын улмаас зарим бүс нутагт цахилгаан хангамж болон бусад суурь үйлчилгээ нэг жил болон түүнээс удаан хугацаагаар тасалдсан. Хуучин зөвлөлтийн орнуудаас эдийн засаг нь хамгийн их агшсан улсуудын нэг нь Монгол болсон (Помфрет 2002). Энгийнээр тайлбарлавал, зах зээлийн эдийн засгийг удирдах институци нь бүрдээгүй байжээ.

Тус улс шилжилтийн үеийн шуургыг аажмаар давсан. 1992 оны сонгуулийн дараа либералчлалын хурдыг тааруулж, доройтож буй амьжиргааны түвшнийг шийдвэрлэх амлалт өгсөн Засгийн газар байгуулагдсан. 1993 он гарснаар эдийн засгийн уналтын хамгийн хүнд үе дуусч, эдийн засаг аажмаар сэргэж эхэлсэн. Улмаар шинэчлэлийн явц эсэргүүцэлтэй нүүр тулж, засгийн эрхийг ардчилсан замаар сольж, 1996 онд Ардчилсан Холбоо эвсэл засгийн эрх барих болсон. Ийнхүү цаг үе ихээхэн ороо бусгаа байсан ч Монгол Улс орчин үеийн, ардчилсан, зах зээлийн эдийн засагтай болох замналд ийнхүү орсон юм.

Энэхүү бүлэгт Монголын эдийн засагт дүн шинжилгээ хийхдээ тус улсын ардчиллын үйл явцыг хэвшүүлсэн хүчин зүйлс, нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэтгэхэд түлхэц үзүүлэх стратегийг нарийвчлан судалсан болно. Ингэхдээ Монголын өвөрмөц түүх, институцийн болон бүтцийн онцлог шинжид анхаарал хандууллаа. Эдгээр онцлог шинжид дараах зургаан зүйлс хамаарч буй болно. Үүнд:

- Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих явц 30 жилийн өмнө эхэлсэн боловч эдийн засаг, институцийн тогтолцоо нь шилжилтийн үеийн төр, нийгмийн олон онцлог чанараа хадгалсаар ирсэн.
- Монголын газар зүйн байршил, байгалийн арвин баялаг нь тус улсын хөгжлийн үр дүнг тодорхойлдог. 3,31 сая хүн амтай (2020 оны

байдлаар), 1,56 сая хавтгай дөрвөлжин км газар нутагтай, хүн амын нягтралаараа дэлхийн хамгийн багад тооцогддог орон тул байгалийн баялагт түшиглэсэн үйл ажиллагаа явуулахад харьцангуй хүчтэй давуу талтай байх боломжтой.

- Далайд гарцгүй дэлхийн 49 орны нэг бөгөөд БНХАУ, ОХУ гэсэн хоёр хүчирхэг эдийн засагтай хил залгадгаараа онцлог.
- Монгол орон нь эрс тэс уур амьсгалтай. Тус улсын ихэнх хэсэг жилийн тэн хагаст цасаар хучигдсан байдаг тул байгаль орчны эмзэг байдалд өртөмтгий байдаг.
- Монголын эдийн засаг нь нийслэл хот болон уул уурхайн салбарт төвлөрсөн ер бусын бүтэцтэй бөгөөд тэдгээр нь дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 65%, 20%-ийг тус тус эзэлдэг. Энэхүү хоёрдмол шинжтэй, жижиг эдийн засгийн ДНБ нь 2018 оны байдлаар ердөө 13 тэрбум ам.доллараар хэмжигдэж байсан.
- Экспортын хэт төвлөрсөн байдал нь Монгол Улсын жижиг эдийн засаг, газар зүйн байршил, байгалийн арвин баялаг зэргээс үүдэлтэй. Тус улс нь Ойрх Дорнодыг эс тооцвол дэлхийн хамгийн өндөр экспортын төвлөрөл (бүтээгдэхүүн болон хүлээн авагч зах зээлийн хувьд)-тэй улс юм.

Судалгааны долоон сэдэвчилсэн бүлгүүдэд суурилсан энэхүү оршил бүлгийг дараах бүтэцтэйгээр бэлтгэсэн болно. Үүнд: эхний хэсэгт Монгол Улсын нийгэм эдийн засгийн онцлог, хөгжлийн тоймыг тусгаж, түүний дараа эдийн засгийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийсэн. Бүлгийн төгсгөлд бодлогын зөвлөмжийг багтаасан.

## 1.1 Эдийн засгийн тойм

### Шилжилтийн эдийн засагт тулгардаг онцлог сорилтууд

Монгол Улс “огцом” либералчлалыг хэрэгжүүлсэн шилжилтийн эдийн засагтай орны олон нийтлэг шинж чанарыг хадгалсаар ирсэн. Либералчлах явцын хурд, цар хүрээнд нөлөөлсөн макро эдийн засгийн бодлогын тохируулга зэрэг 1990-ээд оны эхээр батлагдсан бодлогын шийдвэрүүдийн нөлөө одоо ч мэдрэгдсэн хэвээр байна. Шилжилтийн эдийн засгийн тэргүүлэх судлаач Дуайт Х.Перкинс “Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засаг руу шилжих нь гол төлөв төсөөлснөөс илүү ярвигтай байдаг. Аливаа улс захиргаадалтын тогтолцооноос зах зээлийн тогтолцоонд шилжих үед ихэвчлэн олон янзын институцийг заримдаа тэгээс нь бий болгох шаардлагатай болдог. Эдгээр

шинэ институцийн удирдлага хуучин тогтолцооноос тэс өөр аргаар ажиллаж сурах шаардлагатай бөгөөд үүнд цаг хугацаа шаардлагатай юм” хэмээсэн (Перкинс 2018).

Помфрет (2002) уг асуудлыг ихэд ойлгомжтой тайлбарласан байдаг. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих замыг тодорхойлсон сурах бичиг гэж байдаггүй. Гэхдээ шилжилтийн элементүүдийг үнэ, худалдааны шинэчлэл, макро эдийн засгийн бодлого, аж ахуйн нэгжийн шинэчлэл, санхүүгийн шинэчлэл, хөдөлмөрийн зах зээл болон нийгмийн бодлого гэх үндсэн зургаан ангилалд хувааж болно. Монгол Улсын хувьд төсвийн орлого, зарлагын хамаарал буурч, төсвийн алдагдал өндөр бөгөөд тогтворгүй болсноор макро эдийн засгийн бодлогын хяналтаа алдсан шилжилтийн үеийн орнуудын замналаас гажаагүй юм. Гэхдээ энэхүү шилжилтийн үеийг даван туулсан бусад орнуудын адилаар Монгол Улсын Засгийн газар 1990-ээд оны үед Олон улсын валютын сан (ОУВС)-гийн дөрвөн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр макро эдийн засгийн хяналтаа тодорхой хэмжээнд сэргээж чадсан. Харин Монгол Улс нь үнэ болоод олон улсын худалдааны хувьд либералчлалыг түргэн хугацаанд үр дүнтэй явуулж чадсан.

Ихэнх шилжилтийн эдийн засагтай орнуудад зохицуулалтын орчин, өрсөлдөөний бодлого байхгүйн улмаас аж ахуйн нэгжийн шинэчлэл эмч замбараагүй явагдаж, “клептокраци” цэцэглэн хөгждөг. Эдгээр орнуудад өмч хувьчлалаас хүлээж байсан үр өгөөж нь төдийлөн харагддаггүй. Монгол Улсын хувьд ардчиллын замд хурдтай шилжсэнээр эдгээр хүндрэлээс тодорхой хэмжээнд сэргийлсэн байж болох ч төрийн өмчийн хувьчлал төдийлөн цэгцтэй, үр дүнтэй болж чадаагүй гэж үздэг. Санхүүгийн салбарын шинэчлэл ч мөн хүндрэлтэй байсан. Төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооны үед банкнууд нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн хэрэгцээг хангах үндсэн хэрэгсэл болж байснаас үүдэн банкны салбар дахь хямрал шилжилтийн үеийн ихэнх улс орнуудад түгээмэл тохиолддог. Мөн энэ тохиолдолд ихэнх Засгийн газар шинэчлэлийг хэрэгжүүлэхдээ удаан байж, хөрөнгийн хуваарилалтад тавих хяналтад хойрго ханддаг. Банкны салбарын бүтцийн төвлөрөл ихтэй, санхүүгийн салбарын дуулиант үйл явдлууд өрнөсөн зэргээр Монгол Улс ч мөн энэ хэв шинжээс зайлсхийж чадаагүй. Тухайлбал, Монгол Улсын Хөгжлийн банк (Хөгжлийн банк)-ыг жишээ болгон дурдаж болох юм.<sup>2</sup>

Дийлэнх шилжилтийн эдийн засагтай орнуудын хувьд амьжиргааны түвшин огцом буурч, улсын сектор дахь найдвартай ажил эрхлэлт хумигдаж,

<sup>2</sup> Хөгжлийн Банк 2011 онд байгуулагдсан бөгөөд “ашгийн төлөө, төрийн өмчит хуулийн этгээд” гэж тодорхойлогдсон байдаг.



төрөхөөс үхэх хүртэлх халамжийн тогтолцоо халагдаж (эсвэл хамрах хүрээ нь ихээхэн хумигддаг), цалингийн орлогоос хамааралтай хүмүүст инфляци хүндээр тусах шинжүүд илэрдэг. Эдгээр нь Монгол Улсын шилжилтийн үед ч мөн онцлог байсан.

Нийгэм, эдийн засгийн үр дагаврын хувьд зарим шилжилтийн эдийн засгийн орнууд бага зэргийн бөгөөд харьцангуй богино хугацааны уналт амссан бол (Зүүн Европын хэд хэдэн улс, Вьетнам), ялангуяа мөргөлдөөн гарсан орнууд гамшгийн хэмжээний, удаан үргэлжилсэн үр дагавартай нүүр тулах зэргээр харилцан адилгүй байсан. Либералчлах явцын хурд, чанар нь эргээд харахад эдгээр үр дагаврыг тодорхойлох хүчин зүйл болж байсан. Помфрет (2002: 119) хэлэхдээ, “Европ, Азийн эдийн засгаас хамгийн сайн үзүүлэлттэй байгаа Польш, БНХАУ-ын хувьд аль аль нь хувьчлалыг аажмаар хэрэгжүүлсэн бөгөөд харин хувьчлал харьцангуй түргэн хугацаанд явагдсан ОХУ-ын хувьд төдийлөн сайн үр дүнд хүрч чадаагүй” хэмээсэн. Монгол Улс бусад шилжилтийн эдийн засагтай орнуудаас илүүтэй хурдан хугацаанд өмч хувьчлалыг явуулж, эдийн засгаа чөлөөлсөн нь 1990-ээд онд гаргасан шийдвэрийн тусгалыг хүлээн зөвшөөрсөн гэх асуултыг дагуулж байна. Энэхүү бүлэгт тус сэдвийг олонтоо хөндсөн болно.<sup>3</sup>

## Эдийн засгийн найман онцлог баримт

Монголын эдийн засгийн онцлог, түүний хөгжлийн замнал, үр дүнгийн талаар туурвисан бүтээлийн тоо олноор нэмэгдэж байна. Дэлхийн Банк (2018d) нь Монголын хөгжлийн гол бэрхшээлүүдийг макро эдийн засгийн тогтворгүй байдал; эдийн засгийг төрөлжүүлэх хэрэгцээ; ядуурал ба ажилгүйдэл; дэд бүтэц, тээвэр болон хүрээлэн буй орчныг сайжруулах шаардлага; мөн засаглал гэж тодорхойлсон байна. АНУ-ын ОУХА (2010) нь эдгээртэй төстэй өргөн хүрээний асуудлуудад анхаарал хандуулсан байна, үүнд: эдийн засгийг төрөлжүүлэх хэрэгцээ; улсын геополитикийн байршил; инфляци; дотоодын санхүүгийн салбарын хөгжил; ядуурал, ажилгүйдэл болон эдийн засгийн ялгаатай байдалд хамаарах нийгмийн зорилтууд; хүнсний аюулгүй байдал; дэд бүтэц ба тээвэр; байгаль орчин; мөн засаглал ба төлөвлөлт тус тус хамаарна. Харин ОУВС нь Дүрмийн IV зүйл болон хөтөлбөрийн гэрээний дагуу явцын хяналт тавих үүргийнхээ хүрээнд ОУВС (2008с), ОУВС (2018с) гэх зэрэг Монгол Улсын эдийн засгийн талаар хэд хэдэн тайлан боловсруулсан бөгөөд эдгээр тайланд тусгасанчлан, Монголын эдийн засгийн хөгжил, чадавхийг тодотгодог найман онцлог баримтыг дор тусгасан болно.

<sup>3</sup> Россаби (2005) нь энэ хугацаанд хамааралтай улс төрийн мэтгэлцээн, харилцан зөрчилдөөнтэй онолын талаар судалсан. Гриффин (1995) нь шинэчлэлийн талаар анхлан шүүмжлэлтэй үнэлгээ өгсөн. Тэдний олж мэдсэн хэд хэдэн үр дүн, тухайлбал хөдөө аж ахуйн салбарын тусгай хэрэгцээнд анхаарал хандуулдаггүй зэрэг нь зөв болох нь батлагдсан юм.

**Түүхэн уламжлал.** Өмнө дурдсанчлан, Монголын өөрийн гэсэн онцлог түүхийг сөхөж байж тус улсыг ойлгох боломжтой. Монгол Улс орчин үеийн түүхээ Чингис хааны үеэс буюу 1206–1227 онуудад Монголын эзэнт гүрэн Ойрх Дорнод ба түүнээс цааших нутгийг эзэлсэн үеэс эхлэлтэй гэж үздэг. Монголын эзэнт гүрний үед Ази, Европын хоорондох худалдааны замаар зорчиход харьцангуй аюулгүй болж, улмаар худалдаа өргөжиж эхэлсэн. Монголчууд дэлхий ертөнцөд нээлттэй байж, харийн соёл иргэншилд ээлтэй ханддаг байсан. Тус улс нь 20-р зууны ихэнх он жилүүдэд Зөвлөлт Холбоот Улс ба Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл (КОМЕКОН)-тэй холбоотой байсан ч эдийн засаг, улс төр болон нийгмийн хувьд тусгаарлагдсан байсан. 1960 онд Хятад-Зөвлөлтийн харилцаа муудсаны дараачаар Монгол Улс түүхэн чухал харилцаатай байсан хөрш болох БНХАУ-тай холбоо тасарч, 1987 он хүртэл харилцаа хэвийн болоогүй. 1990 он гарснаар бүх зүйл өөрчлөгдөж, авторитар төр ардчилсан сонгуульд зам тавьж, олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт нээлттэй болж, иргэд нь чөлөөтэй зорчиж, зах зээлийн зарчмаар үнэ тогтоож, төрөөс бүх нийтийг ажлаар хангах болон насан туршид нь асарч хандах үүрэггүй болж, хувийн өмчтэй байх нь энгийн үзэгдэл болсон.

Ингэснээр Монгол Улсын бодлого боловсруулагчид болон нийгэм бүхэлдээ шинэ, нээлттэй орчинтой анхлан нүүр тулж, гадаадын худалдаачид, хөрөнгө оруулагчид, ялангуяа тус улсад орж ирсэн уул уурхайн туршлагатай компаниудтай харилцах туршлага дутагдаж байсан. Хэдийгээр ардчиллын үндэс хурдтай тавигдсан ч хараат бус байгууллагууд, эрх зүйн системийн хяналтын тогтолцоо, сонгуулийн үйл явц, мөнгө, санхүүгийн зохицуулагч байгууллагууд болоод засгийн газрын бусад бүтэц хараахан бүрдээгүй байсан. Инфляци ч мөн маш хурдацтай өссөн. Дотоодын мөнгөн тэмдэгт олон улсын арилжаанд нэвтэрснээр ханшийн савлагаатай болсон. Гадаад харилцаагаа хурдацтай өөрчлөгдөж буй дэлхийн дэг журамтай нийцүүлэн тогтоох шаардлага тулгарч эхэлсэн. Ядуурал ба тэгш бус байдал газар авахын хэрээр нийгмийн бэрхшээлүүд нэмэгдсэн. Засгийн газарт эдийн засгийн менежментийн туршлага дутагдаж, улмаар гадаад өрийн хэмжээг тогтворгүй түвшинд хүргэсэн. Россаби (2005)-гийн тэмдэглэснээр, “цочролын эмчилгээ” болон түүнтэй нэр холбогдсон байгууллага, хүмүүсийн нэр хүнд муудаж, хожим нь завсрын популист шинжтэй төсвийн болон бусад арга хэмжээ бий болох эхлэл тавигдсан. Эдгээр түүхэн үйл явдал одоо ч мэдрэгдсэн хэвээр байна.

**Ардчиллын хөгжил, институцийн дутмагшил.** Монгол Улс ардчиллын үрийг хурдан хугацаанд бат бөх суулгаж чадсан (Россаби 2005). Ингэснээр Монгол Улс 1992 болон 1993 оноос хойш 4 жилд нэг удаа үндэсний хэмжээнд

сонгууль явуулдаг болсон. Хоёр гол нам болох Монгол Ардын Нам<sup>4</sup> болон Ардчилсан нам улс төрд давамгайлж ирсэн бөгөөд улс төрийн өөрчлөлт ерөнхийдөө тайван замаар явагдаж ирсэн. Тиймээс Монгол Улс нь улс төрийн эрх чөлөөний индексээр өндөрт жагсдаг бөгөөд энэ талаар Д.Бямбажав болон Жулиан Диеркес нарын бичсэн 7-р бүлэгт нарийвчлан тусгасан болно. Монголын хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээ нь ямар нэг хязгаарлалтгүй байдаг бөгөөд тус улсад иргэний нийгэм сайтар хөгжсөн.

Мөн хүн амын бичиг үсэг тайлагдалтын хувь өндөр, хүйсийн тэнцвэртэй байдал сайн, гадаадад зорчих эрх нээлттэй, амьжиргааны түвшин сайжирсан гэх зэргээр давуу талууд бий хэдий ч ардчилсан эрх, эрх чөлөөг дагалдах институцийн чанараа сайжруулах шаардлага хэвээр байна. Хэдийгээр иргэдийн дуу хоолой, хариуцлагын механизм нь чухал ч институцийн чанар төдийлөн сайжраагүй нь асуудал дагуулсаар байна. Тухайлбал, төрийн албаны шинэчлэл удаашралтай явагдаж, төрийн албан хаагчид цалин, хөлс багатай байгаа нь тэдгээрийн олонх нь давхар ажил хийх, орлогын нэмэлт эх үүсвэртэй болох арга замыг эрэлхийлэхэд хүргэж байна. Засаг өөрчлөгдөхөд төрийн албан хаагчдын халаа сэлгээ ч ихээр хийгддэг. Засгийн газарт тавих хараат бус хяналт (сонгуулийн саналыг эс тооцвол) сул бөгөөд өндөр хариуцлагатай эрх мэдлийг хэрэгжүүлэх авлигатай тэмцэх газар тус улсад дутагдаж байна. Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ болон шинжлэх ухааны ололтыг хөдөө аж ахуйн салбарт нэвтрүүлэх үйлчилгээ зэрэг төрийн анхан шатны үйлчилгээний чанар социализмын үеийнхээс суларсан болохыг иргэдийн ярианаас харж болохоор байна. Түүнчлэн бие даасан, итгэмжит эрх зүйн тогтолцооны хөгжил аажмаар явагдсаар байна.

**Газарзүй.** Монгол Улс ихээхэн өвөрмөц, сорилт арвинтай газар зүйн байрлалд оршдог. Газарзүйн байршил эдийн засгийн хөгжлийг голчлон тодорхойлох хүчин зүйл болдог талаар системчилсэн олон улсын баримт нотолгоо байхгүй хэдий ч Монгол Улсын хувьд газарзүйн онцлог байршил нь хүн амын суурьшил, эдийн засгийн үйл ажиллагаа, эдийн засгийн ерөнхий хөгжил, хэв шинж бүрэлдэн тогтоход зарим байдлаар нөлөөлж ирсэн. Газарзүйн зарим хүчин зүйл хөгжлийн замд саад тотгор болох нь ч бий.

Монгол Улс нь далайд гарцгүй улсын хувьд Тяньжин, Владивостокийн далайн боомтуудад хүрэхийн тулд БНХАУ болон ОХУ-ын газар нутгаар дамжих шаардлагатай болдог учраас тэдгээр улсуудаас хамаарах эдийн засаг болон стратегийн хараат байдлыг нэмэгдүүлдэг. Ачаа тээврийг газраар явуулахад

<sup>4</sup> Монгол Ардын Нам нь Монгол Ардын Хувьсгалт Намын залгамжлагч улс төрийн нам юм. 2010 онд тус нам нэрээсээ “Хувьсгалт” гэх үгийг хасахаар шийдсэн. Энэхүү шийдвэрийн дараа намын салан тусгаарлагч бүлэг Монгол Ардын Хувьсгалт Нам гэсэн нэрийг ашиглан шинэ нам байгуулсан.

хил дамнасан авто болон төмөр замын сүлжээнд холбогдсон байх, хоёр талын ачаа тээвэрлэлт болон гаалийн байгууламжууд түргэн шуурхай, үр ашигтай ажиллах зэрэг шаардлагууд үүсдэг. Ричард Помфретын бичсэн 6-р бүлэгт дурдсанаар, Монгол Улс хоёр хөрштэйгөө үр дүнтэй хамтран ажиллах боломжууд байсаар ирсэн хэдий ч харилцаагаа улам бүр сайжруулах, хоёр талын эв түнжинг муутгагч олон талт хүчин зүйлсийг арилгах шаардлага мөн байсаар байна.

Далайд гарцгүй байх нь хил дамнасан хамтын ажиллагааны хувьд боломж, бэрхшээлийн аль алиныг дагуулдаг. Монгол Улсын хил дагуух бүс нутгаар бараа, бүтээгдэхүүний тасралтгүй урсгалыг авчрах эдийн засгийн чөлөөт бүс байгуулах боломжтой юм. Энэ чиглэлээр тодорхой ахиц дэвшил гарч байгаа ч илүү ихийг хийх шаардлагатай байна. Монгол Улсыг БНХАУ, ОХУ (цаашлаад Япон болон БНСУ)-тай холбох Зүүн хойд Азийн супер сүлжээ зэрэг эрчим хүчний хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжууд арвин байна. Мөн дэлхийн эх газрын хамгийн том усны нөөц бүхий ОХУ-ын Байгаль нуурт Монголын голууд цутгадаг тул хойд хилийн орчимд усан цахилгаан станц барих замаар хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжтой.

Монгол Улсын хүн амын суурьшилт жигд бус тархалттай байна. 3.31 сая хүн амын тал орчим хувь нь тээвэр болон эрчим хүчний дэд бүтцийн дутагдалд орсон Улаанбаатар хотод оршин сууж байна. Харин хүн амын нөгөө тэн хагас нь хөдөө, орон нутагт нүүдэлчний соёлоор амьдардаг.<sup>5</sup> Тиймээс шаардлагатай дэд бүтэц, ялангуяа зам, харилцаа холбооны дэд бүтцээр хангахад томоохон бэрхшээл тулгардаг. Мөн Монгол Улсын хувьд дотооддоо болон дэлхийн бусад орнуудтай холбогдох агаарын холбоо сайтар хөгжөөгүй бөгөөд цаг уурын эрс тэс байдал нь тээвэр, ложистикийн үйлчилгээ хангалтгүй байхад нөлөөлдөг. Эдгээр нь өвлийн улирлын уртад ихэнх улс орнуудаас тусгаарлагдах нөхцөл болдог.

**Хоёр том эдийн засгийн дунд орших нь.** Монгол Улс нь БНХАУ, ОХУ-тай хил залган оршдог бөгөөд өөрийн эдийн засгаас харилцан 600 ба 100 дахин том эдгээр улсуудтай эдийн засаг, улс төр болон стратегийн харилцаатай байх зайлшгүй шаардлагатай болдог.<sup>6</sup> Монгол Улс нь сайшаахуйц хэмжээнд эдгээр харилцааг амжилттай удирдан чиглүүлж, төвийг сахисан байдлаа хадгалж, “гуравдагч хөрш”-ийн гадаад бодлогын хүрээнд бусад улстай харилцаагаа бэхжүүлсэн.

<sup>5</sup> Улаанбаатарын нэгдүгээр шатлалын хот. Хоёр ба гурав дахь том хотууд болох Эрдэнэт, Дархан нь 100 гаруйхан мянган хүн амтай буюу нийслэлийн нийт хүн амын 6 орчим хувьтай тэнцэнэ. Эрдэнэт, Дархан нь улсын хойд хэсэгт байрладаг; эхнийх нь уул уурхайд суурилсан, дараагийнх нь үйлдвэрлэл, боловсролын салбарт суурилсан хот юм.

<sup>6</sup> Энэ хоёроос БНХАУ-тай зааглах хуурай газрын хил нь илүү урт буюу 4680 километр (км), ОХУ-тай 3490 км орчим урт хилээр зааглагддаг. Монгол Улс Казахстантай бараг хил залгаа (37 км алслагдсан) газартай бөгөөд цөөн тооны казах үндэстэн (хүн амын 5%) Монголд амьдардаг.

БНХАУ нь Монгол Улсын томоохон худалдааны түнш, хөрөнгө оруулагч, технологийн ханган нийлүүлэгч, аялал жуулчлалын эх үүсвэр тул Монгол Улсын тус улстай харилцах харилцаа нь худалдаа, эдийн засгийн томоохон боломжийн зэрэгцээ хоёр талын улс төрийн нарийн төвөгтэй байдлыг бий болгодог. БНХАУ нь тогтвортой өндөр өсөлт үзүүлж байгаа нүсэр зах зээл юм. Тус улсын технологийн дэвшил улам нэмэгдэж, хөдөө аж ахуй салбарын өрсөлдөх чадвар буурахын хэрээр өмнө дурдсан эдийн засаг, худалдааны боломжууд нэмэгдэх юм.<sup>7</sup> Энэ нь Монгол Улсаас ОХУ-тай харилцах харилцаа чухал биш гэсэн үг хэрхэвч биш юм. Далан жилийн хугацаанд ЗХУ-ын дагуул байсан үеэс өвлөгдөн үлдсэн худалдаа, боловсрол болон хэлний чухал харилцаа Монгол Улсад хадгалагдсан хэвээр байна. ОХУ болон Евразийн эдийн засгийн холбоонд нэвтрэх нь тодорхой төрлийн онцлог бүтээгдэхүүнүүдэд илүү чухал байна. Тухайлбал, ОХУ нь эрчим хүчний боломжит чухал ханган нийлүүлэгч бөгөөд Монгол Улсын хувьд Владивостокийн боомтоор транс тээвэр хийх гарцыг хадгалах нь чухал юм. Мөн ОХУ-ын нутгаар дамжин Европын Холбоонд транзит тээвэрлэлт хийх нь Монгол Улсад ашигтай.

**Жижиг эдийн засаг.** Монгол Улс нь хөгжингүй орны нэг хотын дайтай маш жижиг эдийн засагтай улс бөгөөд ДНБ нь ердөө 13 тэрбум ам.доллартай тэнцдэг. Тиймээс, эдийн засгийн хувьд Номхон далайн болон Карибын тэнгисийн жижиг улсуудыг эс тооцвол дэлхийн хамгийн жижиг орнуудын нэг юм. Геостратегийн нөлөөллийг эс тооцвол тус улсын эдийн засгийн хэмжээ нь эдийн засгийн тодорхой үр дагаварт хүргэдэггүй. Өөрөөр хэлбэл, тухайн улсын хэр жижиг байх, эдийн засгийн хөгжил ямар байх хоёрын хооронд тодорхой түүхэн хамаарал байхгүй юм. Энэ хоёр урвуу хамааралтай гэх онолыг зарим судалгаанд дэвшүүлж байсан ч энэ нь томоохон эдийн засагтай улсууд дотогшоо чиглэсэн өртөг өндөртэй арилжааны бодлогыг хэрэгжүүлэх магадлал өндөр байсантай холбоотой юм. Гэсэн ч БНХАУ, Энэтхэг болон Индонез зэрэг Азийн хүн ам ихтэй эдийн засагтай улсууд гадагшаа чиглэсэн бодлого баримталж, хурдацтай өсөж эхэлсэн тул тус онолыг төдийлөн хэрэгсэхээ больсон байна.

Гэсэн хэдий ч эдийн засгийн хэмжээ нь эдийн засгийн бодлогод нөлөөлж байдаг. Иймд бусад байдлаар ижил нөхцөлд жижиг эдийн засагтай улсууд нээлттэй байх шаардлагатай. Ер нь нээлттэй ч байдаг бөгөөд ингэснээр худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжүүд нь томоохон эдийн

<sup>7</sup> Нийт хөдөө аж ахуйн буюу broadacre гэдэг нь ихэвчлэн Австралид үр тариа, тосны ургамал болон бусад таримал үйлдвэрлэх ... эсвэл мах, ноосны зориулалтаар мал маллах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ферм, аж үйлдвэрүүдийг тодорхойлоход хэрэглэгддэг нэр томъёо юм (ЭЗХАХБ, 2001 он). Монгол Улсын иргэд БНХАУ-д визгүй нэвтрэх эрхтэй боловч БНХАУ-ын иргэд Монгол Улсад нэвтрэхэд виз шаардлагатай. Монгол Улс найман гишүүнтэй Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад гишүүнээр элсэх хүсэлт гаргаагүй боловч ажиглагчийн статустай орон юм.

засгуудын давуу талыг ашиглах боломжтой болдог. Мөн эдгээр улсын хувьд экспортын орон зай илүү төвлөрсөн байх талтай тул Засгийн газар нь хязгаарлагдмал хүрээний экспортын хамаарлаас үүдэх аюулаас сэрэмжлэх хэрэгтэй. Түүнчлэн жижиг улсын эдийн засаг долларжих хандлагатай байдаг бөгөөд ялангуяа мөнгөний бодлого хэрэгжүүлдэг байгууллагад итгэх итгэл сул үед, мөн макро эдийн засгийн чанартай удирдлага бүхий хөрш томоохон эдийн засаг нь эдийн засаг, худалдааны харилцаанд давамгайлж байх тохиолдолд долларжих хандлага илүү өндөр байдаг. Маш жижиг эдийн засагт техникийн ур чадвартай хүний нөөц бага байдаг тул олигархи институцийн хяналт газар авах нь бий. Тиймээс энэ төрлийн улсууд олон улсын хөдөлмөрийн зах зээлээс техникийн ур чадвартай хүний нөөц авч ашиглах нь зүйтэй юм.

Дээрх бүх хүчин зүйлс Монгол Улсад хамааралтай бөгөөд Према-Чандра Атукорала болон Маттиас Хелблэ нарын 5-р бүлэгт нарийвчлан өгүүлснээр тус улс нь харьцангуй нээлттэй худалдааны дэглэмтэй улс юм. Хэдий хөрөнгө оруулалтын дэглэм нь харьцангуй нээлттэй хэдий ч зарим талаараа төдийлөн ил тод байж чаддаггүй. Эдийн засаг дахь долларжилтын түвшин бага байгаагаас төв банк болох Монголбанкинд итгэх иргэдийн итгэл өндөр байдаг гэж дүгнэж болохоор байна. Тус улсын мөнгөний бодлогын түүхийг сөхөхөд ч энэ дүр зураг ажиглагдаж байна. Харин институцийн хувьд гацаа үүсгэж буй томоохон бэрхшээл илхэн байгаа тул улс төрийн тогтолцооны хүлцэх хэмжээнд хараат бус, техникийн мэдлэг, ур чадвартай хүмүүсийг шүүх эрх мэдлийн байгууллагуудад авч ажиллуулах шаардлага маргаангүй байна.

**Арвин их байгалийн баялаг.** Монгол Улс нь арвин их байгалийн баялагтай улс юм. Алт, газрын тос, байгалийн хий, уран, газрын ховор эрдэс бодисоос гадна нүүрс, зэсийн асар их нөөцтэй. Тус улсын газар нутгийн дийлэнх хэсэгт геологийн судалгаа хараахан хийгдээгүй байгаа тул батлагдсан нөөцөө ирээдүйд нэмэгдүүлэх боломжтой. Тиймээс Засгийн газраас улсаа “Азийн Кувейт” болох боломжтой гэх мэдэгдэл хийсэн нь хэтрүүлэг биш байж болох юм. Мөн Монгол Улс нь сэргээгдэх эрчим хүч, түүний дотор нар, салхины эрчим хүчний өндөр ирээдүйтэй бөгөөд ОХУ-тай харилцан тохиролцож чадвал усны эрчим хүчний нөөц боломж ч арвин бий. Энэхүү арвин их нөөц нь боломж, бэрхшээлийн аль алиныг дагуулдаг. Монгол Улс “баялгийн хараал”-ын талаарх судалгаагаар дэвшүүлсэн олон асуудлыг бодитоор туулсан (Sachs and Warner 2001). Александр Леманн болон Жункю Ли нар 2-р бүлэгт тусгасанчлан, тус улс эдийн засгийн хямралаас гарах ОУВС-гийн зургаан удаагийн хөтөлбөрт<sup>8</sup> хамрагдах шаардлагатай болсон нь 1990-ээд оны эхэн

<sup>8</sup> Монгол Улс 1991 онд элссэнээсээ хойш ОУВС-гийн зэргийн зургаан хөтөлбөрт хамрагдсан. Эхнийх нь 1991 оны богино хугацааны хөтөлбөр, дараа нь 1993, 1997 оны сайжруулсан бүтцийн тохируулгын хөтөлбөр, 2001 оны ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөр, 2009 оны богино хугацааны хөтөлбөр; болон 2017 онд өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр (ОУВС 2009, 2019б) тус тус болно.

үеийн шилжилтийн үед тулгарсан бэрхшээлүүд төдийгүй, арвин их байгалийн баялгаа макро эдийн засгийн бодлогын хүрээнд үр дүнтэй удирдаж чадахгүй байгааг илтгэж буй юм.

Үүнийг төсвийн бодлогоо хэрхэн явуулж ирснээс тодоор харах боломжтой. Засгийн газар түүхий эдийн өсөлтийн үед гол төлөв нэмж зээл авах замаар төсвийн алдагдлыг нэмэгдүүлж ирсэн гэдэг утгаараа төсвийн бодлого ерөнхийдөө мөчлөг дагасан шинжтэй байсаар ирсэн. Заримдаа уул уурхайн гэнэтийн ашиг олно гэх хүлээлт гаргасан ч төдлийлөн ашиг олж чадаагүй, эсхүл ашигтай байдал удаан үргэлжлээгүйн улмаас төсвийн алдагдал улам нэмэгддэг хандлагатай байна.

Байгалийн баялгийн хараалын онолд заасанчлан, Монгол Улс байгалийн нөөц баялгийн зарим асуудлыг, тэр дундаа гурван хүчин зүйлсийг сайн удирдаж чадалгүй ирсэн. Тэдгээрийг дараагийн хэсэг болон 2-р бүлэгт илүү нарийвчлан авч үзсэн болно. Нэгдүгээрт, уул уурхайн татварын зохицуулалт төдийлөн оновчтой бус байсан болохыг Намхайжанцангийн Дорждарь, Марсель Шредер нар 3-р бүлэгт харуулсан. Үе үеийн засгийн газрууд гадаадын хөрөнгө оруулалтад нээлттэй, тэргүүн туршлага бүхий татварын стратеги (магадгүй ашигт малтмалын түрээсийн татвар хэлбэрээр) баримтлахаас илүү төрийн хувь эзэмшлийн хөрөнгө оруулалт хийх, гадаадын хөрөнгө оруулалтын бодлогоо харьцангуй таатай бусаас бүрэн нээлттэй байдлын хооронд савлуулах зэрэг шийдлүүдийг сонгож, улмаар уул уурхайн хөрөнгө оруулагчдын шаардах эрсдэлд суурилсан өгөөжийг нэмэгдүүлэх болсон.

Хоёрдугаарт, туршлагатай шинжээчдийн санал нэгдэж буйгаар Монголын байгалийн баялагт түшиглэсэн огцом өсөлт нь институцийн доройтол, нийгмийн итгэлцлийг бууруулсан. Энэ нь төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооноос зах зээлийн эдийн засагт шилжсэний дараачаар хүчирхэг, хараат бус, авлигаас ангид институцийг хараахан байгуулж чадаагүй байхад уул уурхайн өсөлт явагдсанаас үүдэлтэй гэж үзэж болох юм.

Гуравдугаарт, уул уурхайн өсөлтийн үр өгөөжийг тэгш бус хуваарилсан хэмээн ихэнх ард иргэд үзэж буй. Баяржаргалын Ариун болон Хайди Эр-Дупуй нар 8-р бүлэгт өгүүлсэнчлэн, үе үеийн засгийн газрууд энэ хугацаанд нийгмийн зарцуулалтыг нэмэгдүүлсэн боловч ерөнхийдөө зорилтот бүлэгтээ чиглээгүй бөгөөд өсөлт саарахад дагаж хумигдаагүй байна.

**Тэлэлт-агшилтын мөчлөг.** Түүхий эдийн экспортын хэлбэлзэл, худалдааны гол түншүүдийн бизнесийн мөчлөгөөс ихээхэн хамааралтай шилжилтийн эдийн засгийн бүтцийн онцлог нь эдийн засгийн өсөлтийг яалт ч үгүй савлуулах

үр дагавартай юм. 1990-ээд оноос хойш ДНБ-ний жилийн дүн 20%-ийн агшилтаас 17% -ийн өсөлтийн хооронд хэлбэлзэж байснаас харахад дэлхийн хамгийн өндөр савлагаатай эдийн засагтай улсад тооцогдох нь гарцаагүй юм. 2010 оноос хойш жилийн өсөлт 1.2% -аас 17.3% хүртэл хэлбэлзэж ирсэн.

Хоёрдугаар бүлгээс үзэхэд Монгол Улсын макро эдийн засгийн удирдлага зарим үед энэ хэлбэлзлийг нэмэгдүүлсэн. Төсвийн бодлого нь ерөнхийдөө мөчлөг дагасан шинжтэй байсаар ирж, улсын төсөв нь олон жил алдагдалтай явснаас өр хуримтлагдан, эдийн засаг нь олборлох салбар болон уул уурхай дагасан хөрөнгийн урсгалаас ихээхэн хамааралтай болж, улмаар ОУВС-гийн шаардлагад нийцсэн хөтөлбөр хэрэгжүүлэхээс өөр аргагүй болсноор эдийн засгийн агшилт нь улам гүнзгий туссаар ирсэн. Нийлүүлэлтийн талын цочрол, мөчлөг дагасан төсвийн тэлэлт, төгрөгийн ханшийн сулралт зэргээс үүдсэн инфляци тасралтгүй өссөн бөгөөд валютын бодит үйлчлэх ханш чангарсан нь эдийн засгийн өрсөлдөх чадварыг сулруулсан. Эдгээр асуудлыг шийдвэрлэх урт хугацааны цорын ганц шийдэл нь бүтцийн шинэчлэл хэрэгжүүлэх, ямар нэг хэлбэрийн хараат бус баялгийн сангийн механизмыг нэвтрүүлэх замаар эдийн засгийг түүхий эдийн үнийн савлагаанаас бага ч гэсэн тусгаарлах төсвийн болон мөнгөний бодлогын хүрээ юм.

**Байгаль орчны тулгамдсан асуудал.** Монгол Улс нь өөрийн онцлог шинж чанарт тулгуурласан болон хөгжиж буй олон орнуудад нийтлэгээр тулгардаг байгаль орчны асуудлуудтай тулгарч буй юм.<sup>9</sup> 1990-ээд оны либералчлалын дараах институцийн өөрчлөлт бэлчээрт ихээхэн хүнд дарамт авчирсан. Зах зээлийн эдийн засагт шилжсэнээр малыг иргэдэд хувьчилсан бол газар нь нийтийн эзэмшлийнх хэвээр үлдсэн байна (Лхагвадорж нар. 2019 он). Үүний үр дүнд 1990 онд 25 саяар тоологдож байсан малын тоо толгой өдгөө 68 саяд хүрч, мал сүрэг асар их өссөн. Үүний нөлөөгөөр мал аж ахуйн эдийн засагт бэлчээрийн даац хэтэрсэн буюу малын тоо толгойг тогтвортой түвшинд байлгах институцилагдсан механизм байхгүй болж, бэлчээр нутаг “нийтийн өмчийн эмгэнэл”-тэй бодитоор нүүр тулсан. Адуу, тэмээ, хонь болон үхэр сүрэг гэхээсээ илүү бэлчээрт илүү нөлөөтэй ямаан сүргийн тоо хурдацтай өсөн нэмэгдэж байна. Гэсэн хэдий ч ямааны ноолуур нь Монголын өсөлттэй яваа ноолуурын үйлдвэрүүдийн түүхий эд тул малчдад хамгийн их орлого авчирдаг.

Бэлчээрийн даац хэтэрснээр өнгөн хөрсний чанар алдагдаж, хөрсний элэгдэл хурдасч, улмаар уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй говийн цөлжилтийг тэлж, улам бүр дордуулж байна. БНХАУ болон Монгол Улсын

<sup>9</sup> Монгол Улсын байгаль орчны асуудлыг илүү нарийвчлан судлахыг хүсвэл Дэлхийн Банк (2018d, IV хэсэг)-ны мэдээллийг харна уу.



бэлчээрийн жилийн алдагдал 3600 хавтгай дөрвөлжин км хүрэхээр байна. Үүнийг шийдэхийн тулд малын тоо толгойг зүй зохистой оновчтой түвшинд нь хүртэл бууруулах, БНХАУ-ын нэгэн адилаар цөлийн шуурганы эсрэг эрчимтэй ойжуулах (Фой, Кюунг, болон Мээр 2019 он), усны менежментийн арга хэмжээг илүү нухацтай авч үзэх зэрэг шаардлага тулгарч байна.

Малын тоо толгой эрс хурдацтай нэмэгдэж буй нь малын эрүүл ахуйд мөн асуудал үүсгэж байна. Социализмын үеийн мал аж ахуйн тогтолцоо нуран унаснаар Монгол дахь малын эрүүл ахуй муудаж, улмаар тус улсын мах, амьд мал экспортлох боломжийг хязгаарлаж байна. Жишээлбэл, Ейкидикигийн хорио цээрийн фермийн төсөлд мал нядалгааны нэгдсэн байгууламжийг багтаасан байсан бол орон нутагт бий болгох ажлын байр хэд дахин өндөр байх байсан. Мөн барууны орнуудын жижиглэнгийн худалдааны томоохон сүлжээнүүд байгаль орчны доройтол, амьтны эрхийн зөрчилтэй холбоотой хэрэглэгчдийн эсэргүүцэлтэй тулгарч байдаг тул дэлхийн ноолуурын экспортын зах зээлд нэвтрэхэд илүү хүндрэлтэй болж байна (Далтон 2019 он).

Улаанбаатар хот болон бусад хот суурин газруудад байгаль орчны ноцтой асуудал тулгарч байна. Өвлийн улирлын уртад нийслэл хот дэлхийн хамгийн их бохирдолтой хотуудын нэг болдог. Энэхүү бохирдлын 80 орчим хувь нь төвийн шугам сүлжээнд холбогдоогүй гэр хорооллын 220 мянган өрх нүүрс түлж буйтай холбоотой юм. Улаанбаатар хот нь анх байгуулагдахдаа 300,000 орчим хүн амд зориулагдан төлөвлөлт хийгдсэн хот бөгөөд хөдөөнөөс хотруу чиглэсэн их хэмжээний шилжилт хөдөлгөөнийг хүлээн авах боломжгүй юм. Нөхцөл байдлыг хүндрүүлэх өөр нэг хүчин зүйл бол хотын эрчим хүчний 80 хувийг хангадаг, нүүрсээр ажилладаг Зөвлөлтийн үеийн цахилгаан станц юм. Мөн хотыг тойрон хүрээлэх уулс нь утааг түгжиж байдаг. Түүнчлэн Улаанбаатар хотын үеэ өнгөрөөсөн нийтийн тээврийн систем нь замын хөдөлгөөний түгжрэлийн эх үүсвэр болсон авто тээврийн хэрэгслийн тоог асар их нэмэгдүүлэхэд хүргэсэн.<sup>10</sup>

Монгол Улс хатуу түлшийг их хэмжээгээр ашигладаг тул хүлэмжийн хийн ялгаруулалт ихтэй орон юм. Төрөөс татаас авдаг эрчим хүчний компаниудыг дэмжихийн тулд тус улсын алдагдалтай ажилладаг томоохон төрийн өмчит аж ахуйн нэгжүүд бүтээгдэхүүнээ зах зээлийн бус, дарсан үнээр нийлүүлэх шаардлагатай болдог. Түүнчлэн уул уурхай нь байгаль орчинд эрсдэл учруулж болзошгүй юм. Тухайлбал, угаасан нүүрс үйлдвэрлэхийн тулд улам бүр ховордож буй түүхий эд болох усыг их хэмжээгээр ашиглах шаардлагатай болдог.

<sup>10</sup> Тус асуудлыг шийдвэрлэх нэг түр зуурын шийдэл нь Японоос орж ирэх Toyota Prius автомашины импортод татварын хөнгөлөлт эдлүүлэх байсан.

## 1.2 Эдийн засгийн гүйцэтгэл


### Эдийн засгийн өсөлт

Монгол Улсын эдийн засгийн өсөлт тогтворгүй байсаар ирсэн (Зураг 1.1). Зөвлөлт холбоот улсаас авах тусламж зогсож, огцом либералчлах шинэчлэл хэрэгжүүлсний дараачаар шилжилтийн эдийн засагтай бүхий л улсуудын нэгэн адилаар эдийн засаг огцом агшсан. Улмаар 1990-ээд оны дунд үеэс эдийн засаг сэргэж эхэлсэн ч өрийн хуримтлалаас үүдэн өнгөрсөн зууны сүүлчээр дахин уналтад орж эхэлсэн. 21-р зууны эхний арван жилд буюу 2008 оны дэлхийн санхүүгийн хямрал (ОУВС-ийн шинэ хөтөлбөр эхлэх үндэс болсон) тохиох хүртэл өсөлт эрчимтэй байсан. Гэсэн хэдий ч энэ нь V хэлбэрийн хямрал байсан бөгөөд 2011-2013 онуудад уул уурхайн салбар огцом өсөлт үзүүлж, мөн БНХАУ-ын хурдтай өсөлт тасралтгүй үргэлжилсээр байснаас үүдэн эдийн засаг 3 жил дараалан хоёр оронтой тоогоор өссөн. Улмаар тухайн үед Монгол Улс зурвасхан хугацаанд дэлхийн хамгийн хурдтай өсөлттэй эдийн засагтай улсын тоонд багтаж байсан. Гэхдээ 4-р бүлэгт онцолсноор энэ өсөлт тогтвортой байсангүй. 2016 он гэхэд өсөлтийн түвшин 1% хүртлээ унаж, тус улс эдийн засгаа дахин сэргээхийн тулд олон улсын хөтөлбөрт хамрагдахаас өөр аргагүй болжээ.

Энэхүү тогтворгүй байдлыг үл харгалзан, эдийн засгийн түүхэн үеийг үндсэн зургаан дэд хэсэгт хувааж болно, үүнд: (i) эдийн засгийн идвэхжил, амьжиргааны түвшин огцом унасан 1990-1994 оны шилжилт; (ii) 1995-2008 оны дахин сэргэлтийн үе – 2003 он гэхэд нэг хүнд ногдох ДНБ-нийг шилжилтийн өмнөх түвшинд хүргэж, 2000 онд тохиосон өрийн хямралыг түргэн хугацаанд шийдвэрлэж чадсан; (iii) гадаад эдийн засаг, зах зээлийн цочролоос голлон үүдсэн 2009 оны эдийн засгийн огцом хямрал; (iv) уул уурхайн огцом өсөлт, мөчлөг дагасан төсвийн тэлэлт болон хувийн хэрэглээний өсөлт зэргээс үүдэлтэй 2010–2012 оны хурдацтай боловч тогтворгүй өсөлт; (v) гадаад худалдааны нөхцөлүүд болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын гэнэтийн цочрол, мөн өр хурдан хугацаанд тогтворгүй түвшинд хуримтлахад хүргэсэн төсвийн бодлогын тохируулгын дутагдалтай байдлаас үүдсэн уул уурхайн өсөлтийн дараах 2013-2016 оны эдийн засгийн хүндрэл; мөн (vi) гадаад зах зээлийн нөхцөл байдал мэдэгдэхүйц сайжирсан, хөгжлийн түншүүдийн бодлогын дэмжлэгээс үүдсэн 2017-2019 оны өсөлтийн сэргэлт ба тогтворжилт. Үүнээс харахад Монгол Улсын “хэвийн” өсөлт гэж юу болохыг тодорхойлох боломжгүй юм. Гэхдээ шилжилтийн үеийг хасч тооцвол, стандарт хазайлт өндөр хэдий ч 1995-2018 оны жилийн өсөлт дунджаар 5.5% -тай байсан. Эндээс өсөлтийн хамгийн онцлохуйц шинжийг ажиглавал

худалдааны нөхцөл, гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) болон уул уурхайн олборлолттой маш хүчтэй хамааралтай байна гэж дүгнэхээр байна.<sup>11</sup>

**Зураг 1.1: Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт ба нэг хүнд ногдох бодит ДНБ, 1991–2017 он**




ДНБ = дотоодын нийт бүтээгдэхүүн, төгрөг = Монгол төгрөг.

Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорвоо <http://www.en.nso.mn/index.php> (2019 оны 3-р сарын байдлаар).

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн бүтцийн тооцоолол ерөнхий тоймоор байдаг ч тэр бүр гажаад байдаггүй. Азийн бүтээмжийн байгууллагын тооцоонд үндэслэсэн Зураг 1.2-оос харахад социализмын үед нийт бүтээмжийн өсөлт, түүний капитал, хөдөлмөрт оруулах хувь нэмрийн дийлэнхийг “хөлс хүч”-ээр олж авдаг байсан буюу маш их хөрөнгө, хөдөлмөр зарцуулсан ч нийт хүчин зүйлийн бүтээмжийн өсөлт төдийлөн их биш эсвэл сөрөг гардаг байсан. Түүнээс хойш, шинэчлэл хийсэн он жилүүдэд нийт хүчин зүйлийн бүтээмжийн өсөлт илүү хурдацтай явагдаж, уул уурхайн эрчимтэй өсөлтийн жилүүдийг эс тооцвол капиталын тус өсөлтөд оруулах хувь нэмэр социализмын үеийнхээс хамаагүй бага болсон. Зах зээлийн эдийн засагтай дийлэнх улсуудын нэгэн адилаар нийт хүчин зүйлийн бүтээмжийн өсөлт нь ерөнхийдөө ДНБ-ний өсөлтийн хандлагыг дагасан хэвээр байна.

<sup>11</sup> Монгол Улсын үндэсний орлогын нийт өсөлт нь ДНБ-ий хандлагатай маш ойр буюу уул уурхайн эрчимтэй өсөлтийн жилүүдэд харьцангуй хурдацтай өсөж байсан нь гадаадын уул уурхайн компаниудын ашгийг буцаан авсантай холбоотой байх магадлалтай. Гадаадад ажилладаг олон тооны иргэдтэй улс орнуудад мөнгөн гуйвуулга нь ихэнх хазайлтыг үүсгэдэг бол Монголд олон улсын бусад урсгалтай харьцуулахад энэ нь бага байна.

**Зураг 1.2: Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, эх үүсвэрээр, 1971–2015 (%)**



ДНБ = дотоодын нийт бүтээгдэхүүн, НХЗБ = нийт хүчин зүйлийн бүтээмж.

Эх сурвалж: Азийн бүтээмжийн байгууллага. <https://www.apo-tokyo.org> (2017 оны 11-р сард нэвтэрсэн).

Монгол Улсын үндэсний тооцооны статистикт анхаарах хэд хэдэн зүйлсийг тодотгох нь зүйтэй. 1990-ээд онд статистикийн мэдээлэл цуглуулах чадвар суларсан байсан тул тухайн үеийн статистик мэдээллийг ойролцоо тооцоолол гэж үзэх хэрэгтэй. Нүүдэлчин соёлтой оронд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тооцоолол, түүнд оруулж тооцох өрхийн хэрэглээний тооцоог ойролцоо утгаар авахаас өөр арга байдаггүй. Цалин хөлсгүй хийдэг ажлыг, байгаль орчны доройтлыг бүртгэдэггүй, мэдээллийн технологийн үйлчилгээний гарцыг бүрэн бүртгэдэггүй зэрэг бусад нийтлэг хязгаарлалт үүнд мөн үйлчилдэг.

## Эдийн засгийн өсөлтийн харьцуулалт

Монгол Улсын эдийн засгийн гүйцэтгэлийг бусад улстай харьцуулбал ямар байна вэ? Шууд жиших улс байдаггүй тул харьцуулах улсыг сонгохдоо тодорхой хэмжээний үзэмжээр хандах шаардлага гардаг. Харьцуулах үүднээс бүс нутаг дахь өөр гурван шилжилтийн бөгөөд далайд гарцгүй эдийн засагтай улсыг сонгосон болно, үүнд: Казахстан, Бүгд Найрамдах Киргиз болон Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс (БНАЛАУ) тус тус орно. Эдгээр 3 орон нь бага эсхүл дунд орлоготой эдийн засагтай бөгөөд мөн аль аль нь БНХАУ-тай худалдаа, эдийн засгийн нягт харилцаатай улс юм. Монгол Улс нэг хүнд ногдох орлогын хэмжээгээр эдгээр улсуудаас мөн байгалийн баялаг ихтэй орон болох Казахстаны дараа хоёрдугаарт жагсаж байна (Хүснэгт 1.1.).

**Хүснэгт 1.1: Монгол Улс, Казахстан Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс, болон Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн, 2017 он**

Улс	Нэг хүнд ногдох ДНБ Нэрлэсэн \$-р	Доорхтой харьцуулсан 2017 оны бодит \$-р тооцсон нэг хүнд ногдох ДНБ		
		Нэг хүнд ногдох ДНБ Бодит \$-р	Нэг хүнд ногдох ДНБ Бодит \$-р	Нэг хүнд ногдох ДНБ Бодит \$-р
Казахстан	9,030	184.5	242.0	119.8
Бүгд Найрамдах Киргиз	1,220	97.7	163.6	121.6
БНАЛАУ	2,457	374.5	257.4	151.6
Монгол Улс	3,717	229.7	252.8	152.6

ДНБ = дотоодын нийт бүтээгдэхүүн, БНАЛАУ = Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс.  
Эх сурвалж: Дэлхийн Банкны Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүдийн мэдээллийн сан дээр үндэслэсэн тооцоолол. <https://databank.worldbank.org/source/world-development-indicators> (2019 оны 3-р сарын байдлаар).

Эдгээр улсуудаас Монгол Улсын эдийн засгийн өсөлт хүчтэй байна. Нэг хүнд ногдох орлого нь шилжилтийн үеийн түвшнээс 50 орчим хувиар өссөн бөгөөд динамик бүс нутагт байрлах байршлаас ашиг тус хүртдэг БНАЛАУ-тай ойролцоо түвшинд байна. Мөн Монгол Улсын 21-р зуунд үзүүлсэн өсөлт нь Казахстан, БНАЛАУ-тай дөхөж байна. Монгол Улс 2010 оноос хойш түүхий эдийн огцом өсөлтийн ачаар Казахстаныг ардаа орхисон боловч БНАЛАУ-аас илт хоцорсон байна.

## Институци ба засаглал

Засаглалын хувьд Монгол Улсын институцийн болон бизнесийн орчны үзүүлэлтүүд шилжилтийн эдийн засагтай олон орны онцлог шинжүүдийг агуулсан байна. Хүснэгт 1.2-т Дэлхийн Банкнаас гаргадаг Дэлхийн засаглалын индексийн 2000 он (шилжилтийн арван жилийн төгсгөл дэх дүр зургийг харуулсан учир тус индексийг сонгосон), 2017 оны (хамгийн сүүлд гаргасан жил) байдлаарх Монгол Улсын гүйцэтгэлийг гурван өөр улстай харьцуулсан болно. Монгол Улс бүх үзүүлэлтээр харьцангуй сайн оноо авсан байна. Ардчиллын үзүүлэлтүүд (дуу хоолой ба хариуцлага) нь хамгийн өндөр оноо авсан нь хүлээлттэй нийцэж байна. Түүнчлэн улс төрийн тогтвортой байдал, хүчирхийллээс ангид байх, хуульт ёс, авлигад тавих хяналт зэрэг үзүүлэлтээр мөн тэргүүлж байна. Гэвч, засгийн газрын бодлогын үр дүнтэй байдал, зохицуулалтын чанарын хувьд Казахстаны ард орж байна. Олон улсын индексийг гаргахад хувьсагчид гол төлөв нэг хүнд ногдох орлоготой нягт уялдаатай байдаг. Хуульт ёсны үзүүлэлт эрс унасныг эс тооцвол Монгол Улсын засаглалын үзүүлэлтүүд аажмаар бага зэрэг буурч байгааг харж болно.

Харин үүнтэй харьцуулахад, Казахстаны үзүүлэлт ерөнхийдөө сайжирч ирсэн байна.

**Хүснэгт 1.2: Монгол Улс, Казахстан Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын засаглалын үзүүлэлтүүд, 2000 ба 2017 он**

Үзүүлэлт	Казахстан Улс		Бүгд Найрамдах Киргиз Улс		БНАЛАУ		Монгол Улс	
	2000	2017	2000	2017	2000	2017	2000	2017
Дуу хоолой ба хариуцлагын тогтолцоо	20.40	13.79	15.42	33.00	10.95	4.43	59.70	56.16
Улс төрийн тогтвортой байдал, хүчирхийлэл/терроризмоос ангид байдал	49.2	45.24	39.68	30.00	28.04	63.33	75.66	74.76
Засгийн газрын үр дүнтэй байдал	26.67	53.85	36.41	23.08	22.05	38.46	46.67	42.31
Зохицуулалтын чанар	26.15	61.06	50.77	38.46	8.21	25.48	51.28	50.96
Хуульт ёс	14.85	38.46	25.25	17.31	20.30	18.27	51.98	41.83
Авлигад тавих хяналт	9.64	19.71	19.80	12.98	21.32	15.87	45.69	41.83

БНАЛАУ= Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс.

Эх сурвалж: Дэлхийн банк, Дэлхийн хэмжээний засаглалын үзүүлэлтүүд. <http://info.worldbank.org/governance/wgi/#home> (2019 оны 3-р сарын байдлаар).

Монгол Улсын бизнесийн орчны үзүүлэлтүүд холимог үр дүнтэй байна (Хүснэгт 1.3). Бодитоор татсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын ДНБ-нд эзлэх хувиас харвал, эдгээр дөрвөн улсаас гадаадын хөрөнгө оруулалтад хамгийн нээлттэй нь Монгол Улс байна. Энэ бол уул уурхайн маш том хөрөнгө оруулалт татсантай холбоотой дээшилсэн үзүүлэлт болохоос ГШХО-ын бодлогын дэглэмийг төдийлөн сайн илтгэж буй үзүүлэлт биш юм. Дэлхийн Банкнаас гаргадаг “Бизнес эрхлэх нь” тайланд Монгол Улсын эрэмбэлэгдэх байдал нэг хүнд ногдох орлогын хэмжээтэй ойролцоо боловч Казахстаны араас нэлээд тасарсан байна.<sup>12</sup> Транспэрэнси Интернэшнл байгууллагын авлигын төсөөллийн индексээр тус улс 4 орноос хамгийн өндөрт жагссан нь хүснэгт 1.2 дахь мэдээллийг бататгаж байна. Дэлхийн Банкны Ложистикийн гүйцэтгэлийн индексээр Монгол Улс дээрх дөрвөн улсаас хамгийн доогуур

<sup>12</sup> Бусад олон тайланд дурдсаны адилаар төсөлд бизнесийн орчинд үндэслэлгүй, нарийн төвөгтэй олон бэрхшээл тулгардаг байсан талаар мэдээлсэн. Жишээлбэл, салхин цахилгаан станцын төсөл барихын тулд 256 албан ёсны гарын үсэг авах шаардлагатай байсан.

жагссан нь БНХАУ, ОХУ-тай шилжүүлэн тээвэрлэх зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна. Гэхдээ 6-р бүлэгт тэмдэглэсэнээр далайд гарцгүй эдийн засаг, ялангуяа Монгол шиг хүн амын нягтрал багатай орны хувьд энэ индексийг тооцоолоход хэцүү байдаг.

**Хүснэгт 1.3: Монгол Улс, Казахстан Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын микро эдийн засгийн үзүүлэлтүүд, 2018 он**

Үзүүлэлт	Казахстан Улс	Бүгд Найрамдах Киргиз Улс	БНАЛАУ	Монгол Улс
Бизнес эрхлэх нь (нийт 190 орноос);	28	70	154	74
Авлигын төсөөллийн индекс (нийт 180 орноос)	124	132	132	93
Ложистикийн гүйцэтгэлийн индекс (нийт 160 орноос)	71	108	82	130
ГШХО (ДНБ-нд эзлэх хувь) 2017	90.5	77.2	39.2	162.2

ГШХО = гадаадын шууд хөрөнгө оруулалт, ДНБ = дотоодын нийт бүтээгдэхүүн, БНАЛАУ= Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс. Эх сурвалж: Дэлхийн банк, Бизнес эрхлэх нь тайлан, <http://www.doingbusiness.org/en/rankings>; Дэлхийн Банк, Ложистикийн гүйцэтгэлийн индекс, <https://lpi.worldbank.org/international/global>; Транспэрэнси Интернэшнл, Авлигын төсөөллийн индекс, <https://www.transparency.org/cpi2018>; UNCTAD-ын мэдээллийн сан <https://unctad.org/en/Pages/Statistics.aspx> (бүгд 2019 оны 3-р сарын байдлаар).


Далайбуянгийн Бямбажав, Жулиан Диеркес нарын бэлтгэсэн 7-р бүлэгт эдгээр үзүүлэлтүүдтэй харьцуулахад арай таагүй дүр зургийг харуулсан байна. Тухайлбал, Монголчуудын институци болон хоёр намын засаглал давамгайлсан улс төрийн тогтолцоонд итгэх итгэл суларч буйг энэхүү дүн шинжилгээнд онцолжээ. Тус улсын хараат бус сэтгүүлчдийн илрүүлэн, нийтэд дэлгэж байгаа санхүүгийн дуулиант хэргүүд тасрахгүй байгаа нь эдгээр асуудлууд байгаа (мөн нийгмийн сүлжээний хэрэгслүүд эрчимжиж байгаа)-г илтгэх шинж тэмдэг юм. Эдгээр асуудлууд нь эдийн засгийн уналтын үед, тэр дундаа уул уурхайн тэлэлтийн дараах хямралын үеэр ихээхэн маргаан дагуулдаг. Засгийн газар ОУВС-гийн томоохон шинэчлэлийн хөтөлбөрийг дагалдах хатуу нөхцөлүүдийг улс төрийн дорвитой өөрчлөлтүүдгүйгээр хангаж чадсан нь энэхүү улс төрийн тогтолцоо хэр бөх болохыг харуулсан. Гэсэн хэдий ч бусад амжилттай шинэчлэл хийсэн улсаас ялгаатай нь өнөөгийн болон өмнөх хямралын үед удаан хугацааны томоохон шинэчлэлийг эхлүүлэх боломжийг ашиглаж чадаагүй. Авлигыг нухчин дарахын зэрэгцээ одоогийн статус-кво ил дургүйцсэн иргэдийг төлөөлөх чадвартай улс төрийн тоглогчдыг гарч ирэх нөхцөлийг бүрдүүлэх улс төрийн шинэчлэлийг эхлүүлэх боломжтой эсэх нь хараахан тодорхойгүй байна.

## Салбарын өсөлт ба бүтцийн өөрчлөлт

Монгол Улсын салбарын өсөлт, бүтцийн өөрчлөлт нь эдийн засгийн хөгжил, эдийн засгийн шилжилтийн үе (ялангуяа 1990-ээд он), улирлын нөхцөл, ашигт малтмалын хайгуул ба ашиглалт, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт болон бодлогын тусгай интервенц зэрэг хэд хэдэн хүчин зүйлийн харилцан үйлчлэлээс хамаардаг.

1990-ээд оны эхээр бүх салбар, ялангуяа хуучин ЗХУ-тай холбогдсон захиргаадалтын эдийн засгийн суурь болсон төрийн өмчит үйлдвэрүүдээс бүрдэх аж үйлдвэрийн салбар уналтад орсон (Зураг 1.3). Харин малчдын амьжиргааны эх үүсвэрээ хангах чадварын ачаар хөдөө аж ахуйн салбарын уналт хамгийн бага байсан бөгөөд хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарууд түргэн хугацаанд сэргэж, өсөлт үзүүлж эхэлсэн. Гэсэн хэдий ч 2000-2002 оны зуднаар олон тооны мал хорогдож, ургац их алдсан тул хөдөө аж ахуйн гарц эрс буурсан. Чухамдаа, хөдөө аж ахуйн салбарын гарцын чиг хандлага маш өндөр хэлбэлзэлтэй бөгөөд аж үйлдвэр болон үйлчилгээний салбараас илүүтэй их савлаж байдаг нь улирлын нөхцөлөөс ихээхэн хамааралтай болохыг илтгэж байна. Мөн өмнө дурьдсанчлан, 1990-ээд оноос хойш хөдөө аж ахуйн өсөлтийг өдөөж ирсэн суурь хүчин зүйл нь малын тоо толгойн өсөлт юм.

**Зураг 1.3: Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, үйлчилгээний салбарын өсөлт, 1991–2017 он (%)**



Тайлбар: Үндсэн үнээр дотоодын нийт бүтээгдэхүүнд тулгуурлан хийсэн тооцоо. Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо. <http://www.en.nso.mn/index.php> (2019 оны 3-р сарын байдлаар).

Монгол Улс шаардлагатай шинэчлэлийг хийж чадвал хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх өндөр боломжтой. БНХАУ-тай



залгаа хилийн наана Монголын нутаг дэвсгэр дэх Ейкидикийн хорио цээрийн ферм нь үүний нэг тод жишээ юм.<sup>13</sup> БНХАУ-ын энэхүү туршилтын төслийг Си Зиньпин даргын төрийн айлчлалын үеэр албан ёсоор баталсан. Тус ферм нь Монгол Улсаас 60 хүн, БНХАУ-аас 10 хүнийг ажлын байраар хангах хүчин чадалтай. Хорио цээрийн 30 хоногийг өнгөрүүлсний дараа БНХАУ-ын нядалгааны цэг рүү өдөрт 10,000 мал экспортлох тооцоотой байна. Өөрөөр хэлбэл, нэг дор 300,000 орчим толгой мал байрлуулж, жилийн экспортоо 70 сая ам.долларт хүргэх боломжтой юм. Гэсэн хэдий ч, Монголд хангалттай хэмжээний нэмүү өртөг шингээхгүй байна гэх болгоомжлолоос үүдэн тус фермийн үйл ажиллагааг түр зогсоосон.

Энэхүү төслөөс тодорхой сургамжууд авах боломжтой бөгөөд тэдгээрийг 4, 5-р бүлэгт дэлгэрүүлэн тусгасан болно. Тус төсөл нь БНХАУ-тай мал аж ахуйн чиглэлээр харилцан ашигтай хамтарсан үйлдвэр байгуулах боломжтойг харуулж байна. Хамгийн өөдрөг хувилбараар тооцоход, Ейкидики нь Монгол Улсын мал сүргийн тоо толгойг тогтвортой түвшинд буюу 20- 30 саяд байлгах нэг хэрэгсэл байж болох юм. Хөдөө аж ахуй, малын эрүүл ахуйн үйлчилгээг илүү үр дүнтэй ажиллуулснаар Монгол Улс энэхүү төслөөс илүү их нэмүү өртөг дотоодод шингээн авах боломжтой байсан. Жишээлбэл, хэрэв тус улсын мал аж ахуй, мал эмнэлгийн үйлчилгээг үр дүнтэй явуулж, малын эрүүл ахуйн өндөр стандартыг хангаж байсан бол нядалгааны газрыг Монголын хил дотор байрлуулж, улмаар хөдөлмөр эрхлэлтийн ихээхэн боломж шинээр бий болгох байсан.

Дотоодын махны үнийг хөөрөгдөж, ядуурлыг нэмэгдүүлж болзошгүй гэсэн үндэслэлээр энэхүү төсөл (мөн үүнтэй төстэй бусад төсөл)-ийг эсэргүүцэх нь алдаа болохыг үүнээс бас харж болно. Нэгдүгээрт, дээр дурдсанчлан байгаль орчныг хамгаалах үүднээс малын тоо толгойг бууруулах шаардлагатай байна. Ийм төслүүд нь ерөнхийдөө малчдын амьжиргаа, хөдөө орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг олгохын зэрэгцээ Засгийн газрын санаа зовниж буй Улаанбаатар хотын “хэт тэлэлт”-ийн асуудлыг шийдвэрлэхэд нэмэр болох юм. Үүнээс гадна ядуу иргэд цэвэр мал аж ахуйн үйлдвэрлэгчид эсвэл хэрэглэгчид эсэх нь тодорхойгүй байна. Хотын ядуу иргэд мэдээжийн хэрэг цэвэр хэрэглэгчид бөгөөд энэхүү нийгмийн бүлэгт шаардлагатай дэмжлэгийг илүү үр дүнтэй хэлбэрээр хэрэгжүүлэх хэрэгслүүд байдаг.

3-р бүлэгт аж үйлдвэрийн өсөлтөд уул уурхай давамгайлж ирсэн талаар нарийвчлан тусгасан бөгөөд аж үйлдвэрийн салбар 1995, 2001, 2004 болон 2013 онуудад маш өндөр өсөлттэй байсан. Эдгээр онуудад тохиосон өндөр

<sup>13</sup> Ейкидики нь БНХАУ-д төвтэй компани юм. 2018 онд 2.4 тэрбум төгрөгийн цэвэр борлуулалт хийж, 114 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

өсөлтийн гол эх үүсвэр нь уул уурхайн томоохон бүтээн байгуулалт байсан бөгөөд үүнд өмнийн говийн бүс нутаг дахь мега уурхай болох Оюу Толгойн алт, зэсийн уурхайн үйл ажиллагаа эхэлсэн, болоод улсын хойд хэсэгт орших Эрдэнэтийн зэсийн уурхайн үйл ажиллагаа зэрэг нь голлох нөлөө үзүүлсэн.<sup>14</sup> Уул уурхайн үйлдвэрлэлийн гарцны хувьд ч нэлээдгүй хэлбэлзэлтэй байгаа нь гайхах зүйл биш юм. Монгол Улсын үйлдвэрлэлийн салбар жижигд тооцогдох бөгөөд цаашид ч энэ хэвээр байх магадлалтай. Өргөн хүрээний огцом либералчлалын үеэр олон тооны улсын үйлдвэрүүд хаалгаа барьсан. Мөн уул уурхайн тэлэлт нь өсөлтийн томоохон хөшүүрэг болсон үед гол худалдаалдаг бараа, бүтээгдэхүүний салбар болох үйлдвэрлэл болон хөдөө аж ахуйн үйл ажиллагаа нь Голланд өвчний үр дагаварт нэрвэгдэн шахагдсан. Түүнчлэн, Монгол Улсын нээлттэй эдийн засаг нь дэлхийн бага, хагас ур чадвартай үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний гол нийлүүлэгч болох БНХАУ-тай нягт холбогдсон байдаг. Монгол Улсын цалин хөлсний түвшин хөрш болох БНХАУ-ын ӨМӨЗО-ныхоос өндөр байна. Үүгээр зогсохгүй ложистик, эрчим хүчний зардал өндөртэй улмаас нь 4, 5-р бүлэгт дурдсанаар Монгол Улс нь зарим онцгой төрлийн бүтээгдэхүүнээс бусад хөнгөн үйлдвэрлэлийн салбарт өрсөлдөх чадвар багатай гэсэн үг юм.


Бараа, бүтээгдэхүүний салбаруудын өсөлт холимог байгаа нь өдөөгч хүчин зүйлс харилцан адилгүй байгааг илтгэж буй бөгөөд нийт эдийн засгийн идвэхжилд бага зэргийн тогтворжуулах нөлөө үзүүлж байна. Үйлчилгээний салбарын өсөлт илүү тогтвортой боловч зарим үед салбарын ердийн дундаж түвшнээс их хэмжээгээр (0% -аас 17% хүртэл) хэлбэлзэж ирсэн. Уул уурхайн шууд ба дам орлогын нөлөөнөөс ихээхэн хамааран хэлбэлзэж ирсэн төсвийн зарцуулалт нь энэхүү үйлчилгээний салбарын өсөлт дэх хэлбэлзлийн гол шалтгаан байсан. Түүнчлэн хотжилт, орлогын өсөлт болон албан бус эдийн засгийн хумигдал нь үйлчилгээний салбарын өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлс болсон.

Салбарын өсөлт нь ийнхүү ердийн бус хэв маягтай боловч бүтцийн өөрчлөлтийн үйл явц нэлээд уламжлалт хэлбэрээр явж ирсэн (Зураг 1.4). Хөдөө аж ахуйн нийт ДНБ-нд эзлэх хувь 1990-ээд оны дундуур оргил цэгтээ буюу 36% -д хүрч байсан боловч 2000 оны эхээр үйлдвэрлэл, үйлчилгээний өсөлтийн үед тус салбарын гарц багасаж, эзлэх хувь нь хоёр дахин буурсан

<sup>14</sup> Энэ хоёр уурхай нь дэлхийн жишгээр томоохонд тооцогдоно эсвэл Оюу Толгойн хоёрдугаар үе шат дууссаны дараа томд тооцогдох болно. Эрдэнэт үйлдвэр нь Монголын засгийн газрын 51%, ОХУ-ын 49% -ийг эзэмшдэг аж ахуйн нэгж бөгөөд дэлхийн дөрөв дэх том зэсийн уурхай юм. Тус уурхай ДНБ-ий 13.5%, төсвийн орлогын 7%-ийг бүрдүүлдэг. Дээр дурдсанчлан, гадаад түншийн хувьцаагаа өрөөр солих хүртэл Оюу Толгой нь гадаад эзэмшил давамгайл байсан.

бөгөөд одоогийн байдлаар 10-15%-д байна.<sup>15</sup> Харин аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь хэмжээ харилцан адилгүй байсаар ирсэн боловч 30-40% хооронд хэлбэлзэж, аажмаар өсөх хандлагатай байна. Үйлчилгээний салбарын хувьд ихэнх жилүүдэд ДНБ-ий тал орчим хувийг бүрдүүлдэг хамгийн том салбар боловч бас л жилээс жилд хэлбэлзэл ихтэй байна.

**Зураг 1.4: Дотоодын нийт бүтээгдэхүүн, салбараар 1991–2017 он (%)**




Тайлбар: Үндсэн үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд үндэслэн тооцов. Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо. <http://www.en.nso.mn/index.php> (2019 оны 3-р сарын байдлаар).

## Хуримтлал ба хөрөнгө оруулалт

Монгол Улсын эдийн засгийн тогтворгүй өсөлт нь хуримтлал, хөрөнгө оруулалтын хэв маягаас мөн харагдаж байна (Зураг 1.5). Эдгээрийн аль аль нь шилжилтийн эхэн үеэс уналтад орж эхэлсэн бөгөөд, хуримтлалын хувьд 1990-ээд оны үед өрхийн амьжиргааны хэрэгцээнд зориулагдаж, харин бизнес эрхлэх боломж хязгаарлагдмал байснаас улбаалан хөрөнгө оруулалт олигтой өсч чадаагүй. Гэсэн хэдий ч олон улсын хөгжлийн тусламж, төсвийн томоохон алдагдлаар дамжуулан хөрөнгө оруулалт сайжирсан. Эдийн засгийн өсөлт нэмэгдэхийн хэрээр хуримтлал, хөрөнгө оруулалт хоёулаа сэргэж эхэлсэн боловч 2000-аад оны эхээр хуримтлалын хэмжээ буурсан. Монгол Улс дэд бүтэц, уул уурхайн төслүүдээ санхүүжүүлэх хэмжээний дотоодын хуримтлалгүй тул цэвэр капиталын импортлогч улс байсаар ирсэн.

<sup>15</sup> 1991 онд хөдөө аж ахуйн салбарын бүртгэгдсэн хувь хэмжээ 9.4%-тэй тэнцэж, итгэхийн аргагүй бага дүн гарсан бөгөөд шилжилтийн үеийн эхний жилүүдэд үндэсний дансны статистикийг найдвартай хөтлөхөд учирч буй бэрхшээлээс үүдэлтэй байж болох юм.

**Зураг 1.5: Хөрөнгө оруулалт ба хадгаламж, 1991–2017 он**  
(ДНБ-нд эзлэх %)



ДНБ = дотоодын нийт бүтээгдэхүүн.

Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорвоо. <http://www.en.nso.mn/index.php> (2019 оны 3-р сарын байдлаар).

Уул уурхай хурдацтай хөгжихийн хэрээр хөрөнгө оруулалт 2003 оноос эхлэн ДНБ-ий 30 гаруй хувьтай тэнцэж, 2011–2013 оны үеийн эрчимтэй өсөлтийн жилүүдэд 50%-иас дээш давсан. Улмаар энэ үед засгийн газар болон хувийн хэвшлийн зээл эрс нэмэгдсэн бөгөөд энэ нь төсвийн зардлыг мөн нэмэгдүүлсэн. Түүнчлэн Улаанбаатар хотын үл хөдлөх хөрөнгийн салбар эрчимтэй тэлсэн. 2013 оны дараачаар хөрөнгө оруулалтын ДНБ-нд эзлэх хувь уул уурхайн зогсонги байдлаас үүдэн өсөлтийн жилүүдийн түвшингөөс хоёр дахин буурч, засгийн газар төсвийн илүү хянуур бодлого баримтлах шаардлагатай болсон. Уламжлалт бус мөнгөний бодлого үе шаттайгаар дуусгавар болж, энэ хүрээнд эдийн засагт нийлүүлэгдэж байсан мөнгөний нийлүүлэлт зогссон. Хувийн хэвшлийн зээлийн өсөлт саарах, удаашрах чиг хандлага руу орсон. Гэсэн хэдий ч, хуримтлалын түвшин энэ хугацаанд тогтвортой байж ирсэн.<sup>16</sup>

## Макро эдийн засгийн удирдлага


Монгол Улс макро эдийн засгаа хэрхэн удирдаж байсан нь 1990 оноос хойшхи эдийн засгийн хөгжил, өсөлтийн чиг хандлагыг ойлгоход чухал үүрэг гүйцэтгэнэ. 2-р бүлэгт тэмдэглэсэнээр шилжилтийн эдийн засагтай улсуудаас гадна цөөн хэдхэн орнууд Монгол шиг макро эдийн засгийн нарийн төвөгтэй

<sup>16</sup> Хөдөө орон нутгийн нүүдэлчин өрхүүдийн хуримтлалыг тооцоолоход бэрхшээлтэй байгаа тул ялангуяа хуримтлалтай холбоотой тооцоог ойролцоо утгаар гэж үзэх ёстойг анхаарна уу.

сорилтуудыг даван туулах шаардлагатай болж, эдийн засаг, улс төрийн хувьд шилжилт хийсэн. Шилжилтийн хүрээнд төрөөс ихэнх үнийг тогтоодог хаалттай, захиргаадалтын эдийн засгаас нээлттэй зах зээлийн эдийн засаг руу, мөн социалист улс төрийн тогтолцооноос ардчилсан тогтолцоо руу шилжиж, улс төрийн өрсөлдөөний улмаас улсын секторын зардлын зайлшгүй дарамт бий болгоход хүргэсэн. Шилжилтийн үед худалдааны нөхцөлүүд эрс өөрчлөгдөж, 1990 оноос хойшхи ихэнх хугацаанд дэлхийн хамгийн хурдан өсөлт үзүүлсэн том хөрштэй байснаас үүдэлтэйгээр гадаад зах зээлийн томоохон цочролд өртсөн. Монгол Улс 1991 оноос хойш ОУВС-гийн нийт зургаан хөтөлбөрт хамрагдсан болохыг үзвэл тэдгээр бэрхшээлүүд хэр хүнд байсан нь ойлгомжтой. Бодлого боловсруулагчид макро эдийн засгийг хэрхэн илүү сайн удирдахыг аажмаар сурснаар эдгээр нь тус улсад ихээхэн туршлага болсон юм. ОУВС-гийн хөтөлбөрүүдийн гурав нь 1990-ээд онд, бусад нь 2000-аад онд хэрэгжиж байсан.

Бүх шилжилтийн эдийн засгийн нэгэн адилаар Монгол Улс шилжилтийн үед хэт өндөр инфляцитай нүүр тулсан бөгөөд инфляцийн түвшин 1992 онд 300 гаруй хувьтай байсан (Зураг 1.6). Энэ нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүд төсвийн зөөлөн хязгаарлалттай нөхцөлд үйл ажиллагаа явуулж, засгийн газар эдийн засгийн уналтын үед төсвийн зардлаа тогтвортой хадгалахыг хичээсэн зэрэг ердийн шалтгаануудаас үүдэлтэй. Гэвч 1990-ээд оны сүүлчээр засгийн газар эдгээр дарамтыг зохицуулж эхэлсэн. Гол нь нээлттэй зах зээлийн эдийн засагт мөнгөний бодлогыг хэрхэн хэрэгжүүлэх талаар сурч эхэлсэн юм. Улмар инфляци 1998 он гэхэд 6% болж буурсан бөгөөд түүнээс хойшхи хугацааны талд нь нэг оронтой тоонд байсаар ирсэн. Хэдий 2008 онд 22% хүрсэн зэргээр зарим жилүүдэд инфляци дахин өсөж, худалдааны гол түнш орнуудын түвшнээс дээгүүр байсан ч Монголбанк мөнгөний үзүүлэлтийн хяналтаа хэзээ ч бүрэн алдаж байгаагүй юм. Монголбанк харьцангуй чанга мөнгөний бодлого хэрэгжүүлсэн болохыг 1990-ээд оны сүүл үеэс эхлэн бага мөнгө (M1)-ний ДНБ-нд эзлэх хувь гол төлөв 10%-15%-ийн хооронд хэлбэлзэж байснаас харж болно. M2 мөнгөний нийлүүлэлтийн ДНБ-нд эзлэх хувь 1990-ээд оны сүүлчээр 15 орчим хувьтай байсан бол сүүлийн жилүүдэд 50 гаруй хувьтай болсон нь тус улсын банкны салбарын хамрах хүрээ нэмэгдэж байгааг илтгэж буй юм.

Зураг 1.6: Инфляци ба валютын ханш, 1991–2017 он




төг = Монгол төгрөг.

Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, <http://www.en.nso.mn/index.php>; Дэлхийн Банк, Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүдийн мэдээллийн сан, <https://databank.worldbank.org/source/world-development-indicators> (хоёулаа 2019 оны 3-р сарын байдлаар).

Уул уурхайн экспорт эрс эрчимжиж, Голланд өвчний нөлөө илт мэдэгдэж ирсэн жилүүдээс бусад жилүүдэд инфляцийн үр дүнгээс үүдэн олон улсын өрсөлдөх чадвараа сэргээх зорилгоор төгрөгийн нэрлэсэн ханшийг байнга сулруулах шаардлагатай байсаар ирсэн. Зураг 1.7-д 2000 оноос хойшхи төгрөгийн ханшийн хөдөлгөөнийг нэрлэсэн болон бодит үйлчлэх ханшийн хамт харуулсан болно. Энэ хугацаанд төгрөгийн доллартай харьцах ханш тогтмол суларч байсан бөгөөд энэ судалгааг хийх үед 2000 оны үнэ цэнийн 50%-д хүрэхгүй байна. 2009 оны эдийн засгийн хямрал, 2016 болон 2017 оны эдийн засгийн хүндрэлийн үеэр төгрөг хамгийн огцом суларсан. Ингэснээр ОУВС-гийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүрсэн. Нэрлэсэн үйлчилж буй ханшийн хөдөлгөөн нь төгрөгийн доллартай харьцах ханшийн нэг тусгал болж буй бөгөөд энэ нь Монгол Улсын гадаад худалдаанд ам.доллар чухал байр суурь эзэлдэг болон юанийн доллартай харьцах ханш харьцангуй тогтвортой байдагтай холбоотой. Бодит үйлчилж буй ханш нь Монгол Улсын худалдааны гол түнш орнуудтай харьцуулсан нэрлэсэн үйлчилж буй ханш болон инфляцийн нийлмэл нөлөөг илэрхийлнэ. 2015 он хүртэл үргэлжлэн чангарах хандлага ажиглагдаж байсан бөгөөд ялангуяа 2008 он болон 2010 оны дараа Монгол Улсын инфляци өсөж, уул уурхайн түр зуурын эрчимжлээс болж өрсөлдөх чадвар суларч байсан гэсэн үг юм. 2009 оны эдийн засгийн хямрал, 2016 оны эдийн засгийн хүндрэлтэй үеэр нэрлэсэн ханшийг их хэмжээгээр сулруулж байж энэхүү чиг хандлагыг эргүүлсэн. 2017 он гэхэд бодит үйлчилж буй ханш ойролцоогоор арван жилийн өмнөх байдал руу эргэж очсон боловч 2000 онохоос хамаагүй өндөр хэвээр байсан.

Зураг 1.7: Төгрөгийн бодит үйлчилж буй ханш, 2000–2018



ТӨГ = Монгол төгрөг.

Тайлбар: 2000 оны 12-р сард нэрлэсэн ба бодит үйлчилж буй ханшийг 100-тай тэнцүүлэн индексжүүлсэн болно. Уруудах хөдөлгөөн нь сулралтыг илтгэнэ.

Эх сурвалж: Олон улсын валютын сан, Олон улсын санхүүгийн статистик. <https://data.imf.org/regular.aspx?түлхүүр=61545850> (2018 оны 8-р сарын байдлаар).

Эдгээр үр дүнг ойлгохын тулд улс орны макро эдийн засгийн тэнцэл (өөрөөр хэлбэл, төсвийн болон урсгал дансны)-ийн чиг хандлагыг судлах шаардлагатай. Тэдгээрийг Зураг 1.8-д 1990-ээд оны эхэн үеийн ДНБ-ий эзлэх хувиар харуулав (дээр тусгасан Зураг 1.5-д урсгал дансны гүйцэтгэлийг харуулсан, учир нь эдгээр нь хуримтлал-хөрөнгө оруулалтын тэнцвэргүй байдлыг тольдон харуулж буй юм). Эдгээр тэнцлийн дүнд дөрвөн онцлог байдал тод харагдаж байна. Нэгдүгээрт, Монгол Улс шиг өөрийн гэсэн онцлог шинжтэй эдийн засгийн хувьд 2010 он хүртэл эдгээр тэнцэл нь харьцангуй тогтвортой (ДНБ-ий 10%-иас бага) байсан. Хоёрдугаарт, төсвийн тэнцэл энэ хугацаанд бараг байнга алдагдалтай гарсан бөгөөд урсгал дансны тэнцэл ч мөн л ихэнх жилд алдагдалтай гарсан. Эдгээр онцлог байдал нь хүлээлттэй нийцэж байна: урсгал дансны хувьд хөрөнгө оруулалтын олон хэрэгцээг санхүүжүүлэхэд гадаад хуримтлалыг ашигласнаас үүдэж байгаа бол төсвийн хувьд төрөөс үзүүлэх бараа, үйлчилгээг үүний адилаар санхүүжүүлэх хэрэгцээтэй, хөнгөлөлттэй нөхцөлтэй албан ёсны хөгжлийн тусламжийн эх үүсвэр ашиглагдаас үүдэлтэй. Гуравдугаарт, 2011-2013 оны хооронд тус хоёр үзүүлэлт эсрэг чиглэлд орсноор урсгал дансны алдагдал үлэмж хэмжээнд нэмэгдэж, 3 жилийн хугацаанд дунджаар ДНБ-ий 40%-тай тэнцэж байсан. Төсвийн алдагдал бага зэрэг өссөн. Урсгал дансны алдагдлын энэхүү өсөлтөд ГШХО (үүгээр гадаадын шууд хөрөнгө оруулалттай холбоотой

бараа, үйлчилгээний импортыг санхүүжүүлсэн) болон төсвийн тэлэлт, хувийн хэвшлийн зээлийн өсөлт нөлөөлсөн. 3-р бүлэгт тайлбарласанчлан энэхүү өсөлтийн гол хөшүүрэг нь Оюу Толгой ХХК-ийн уул уурхайн томоохон хөрөнгө оруулагч болох Рио Тинто өөрийн хувьцаа зээмшлээ эр төлбөрт хөрвүүлэхээр гаргасан шийдвэр юм. Зээлийн хөрөнгийг маш өндөр ашигтай хөрөнгө оруулалтад зарцуулахгүй л бол ийм хэмжээний урсгал дансны алдагдал нь эр төлбөр үүсгэх магадлалтай тул ямар ч тохиолдолд үүнийг “хямралд шилжих” үе гэж үзнэ. Энэ нь бүтцийн тохируулгын дөрөв дэх үе шатыг авч хэрэгжүүлэхэд хүргэж, 2015 оноос төсвийн болон урсгал дансны алдагдал хамаагүй бага гарсан.

**Зураг 1.8: Төсвийн болон урсгал дансны тэнцэл, 1991–2017 он**



ДНБ = дотоодын нийт бүтээгдэхүүн.


Эх сурвалж: Монголбанк, <https://www.mongolbank.mn/eng/>; Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорвоо, <http://www.en.nso.mn/index.php> (2019 оны 3-р сарын байдлаар).

Макро эдийн засгийн эдгээр тэнцвэргүй байдал нь Монгол Улсын хурдацтай нэмэгдэж буй эр төлбөрөөс харагдаж байна. Зураг 1.9-д ДНБ-тэй харьцуулсан өрийн дөрвөн ангиллыг (засгийн газрын, хувийн салбар, дотоод, гадаад) нэгтгэн харуулсан (мөн 2-р бүлэгт танилцуулсан мэдээллийг үзнэ үү). Уг мэдээллийг харахад 2010 оноос хойш өсөлт нь өрийн эх үүсвэрээр санхүүжүүлэгдэж ирснийг тод харуулж байна. Засгийн газар, хувийн салбарын нийт өр 1997 онд ДНБ-ий 50 хувьд хүрэхгүй байсан бол 2017 онд бараг 300 хувь болж өссөн нь Монгол Улсыг өндөр өртэй орон болгосон. Энэ нь тус улсын эдийн засгийг олон улсын олон улсын зах зээл дэх зээлийн хүүгийн хөдөлгөөнд маш өртөмтгий, эмзэг болгож байна. 2000 оны эхэн үе хүртэл хувийн хэвшил зээл авах хэмжээнд хөл дээрээ босч хараахан чадаагүй байсан, мөн дотоодын санхүүгийн хэрэгсэл цөөн байсан тул өрийн дийлэнх хувийг засгийн газрын



болон гадаад өр эзэлж байсан. Удалгүй дотоодын хувийн салбарын зээл маш хурдан өсч эхэлсэн бөгөөд 2020 он гэхэд ДНБ-ий 35 орчим хувьтай тэнцэх төлөвтэй байгаа бол төсвийн нэгдмэл байдал болон тогтвортой байдлыг хангах засгийн газрын хүчин чармайлтын үр дүнд засгийн газрын өр (ДНБ-тэй харьцуулахад) буурахад хүрсэн.

**Зураг 1.9: Гадаад, дотоод өр, 1997–2017 он**



ДНБ = дотоодын нийт бүтээгдэхүүн.

Эх сурвалж: Монголбанк, <https://www.mongolbank.mn/eng/>; Дэлхийн банк, Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүдийн мэдээллийн сан. <https://databank.worldbank.org/source/world-development-indicators> (2019 оны 3-р сарын байдлаар)

2000-аад оны эхээр Монгол Улсын өрийн хэмжээ болон өрийн бүрэлдэхүүнд томоохон өөрчлөлт гарсан. Энэ өөрчлөлтөд уул уурхайн эрчимтэй тэлэлт, зээлийн эх үүсвэрээр зарим хэсгийг нь санхүүжүүлсэн гадаадын хөрөнгө оруулалт болон хувийн хэвшлийн үсрэнгүй хөгжил гол түлхэц үзүүлсэн. 2010 он гэхэд хувийн салбарын гадаад өр нийт өрийн хамгийн том бүрэлдэхүүн хэсэг болж, 2012 оны байдлаар нийт өрийн талаас илүү хувийг эзлэх болсон. Улмаар нийт дотоод өр нь тус улсын урсгал тэнцлийн ихээхэн алдагдалтай зэрэгцэн огцом нэмэгдэж, 2009 онд ДНБ-д эзлэх хувь 12.5% байснаас 2016 онд 161% болж өссөн байна. Монголбанкны өр төлбөрийг оруулж тооцсоноор улсын секторын нийт өр 2011-2017 онуудад ДНБ-ий 95 хувьтай тэнцэх хэмжээнд хүрч, бараг гурав дахин өссөн.

Засгийн газар болон хувийн хэвшлийн энэ их өрийн ачааллыг бууруулахын тулд Монгол Улс үндсэндээ өр дарах арга замыг эрэлхийлэх шаардлагатай юм. Ингэхийн тулд төсвийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх томоохон алхам хийх, ялангуяа төсвийн зарцуулалтыг илүү няхуур болгоход хүрнэ. 2-р бүлэгт тэмдэглэсэнээр, зарчмын хувьд үүнийг хэрэгжүүлэх макро эдийн засгийн

бодлогын хүрээ бий. 2010 онд батлагдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд төсвийн алдагдлыг ДНБ-ий хоёр хувиас илүүгүй байлгахаар заасан байдаг. Гэсэн хэдий ч төсвийн орлого, ДНБ-ий өсөлтийг хэт өөдрөгөөр төлөвлөж, үүнээс ихэвчлэн зайлсхийсээр ирсэн. Мөн Монголбанк, Хөгжлийн банк зэргээр дамжуулан төсвөөс гадуурх зарцуулалт хийж байсан. Төсвийн бодлого нь мөн мөчлөг дагасан хандлагатай байсаар ирсэн бөгөөд эдийн засгийн тэлэлтийн үед төрийн үйлчилгээний цалингийн сан (албан хаагчдын тоо, цалингийн хэмжээ хоёулаа), нийгмийн халамжийг нэмэгдүүлдэг ч, өсөлт удаашрахад тэдгээрийг аль алиныг нь буцаан хумьдаггүй байсаар байна.

Засгийн газар гадаад бондын эргэн төлөлт хийх томоохон бэрхшээлтэй тулгарсан 2016-2017 оны эдийн засгийн хүндрэлтэй үед хурдан бөгөөд үр дүнтэй ажиллаж чадсан. Тухайн үеийн ДНБ-ий 50 орчим хувьтай тэнцэх 5.5 тэрбум долларын санхүүжилт бүхий ОУВС тэргүүтэй хандивлагчдын багц (Монголбанк, Хятадын Ардын Банк хоорондын своп хэлцлийн шугамыг оруулаад)-ын дэмжлэгийг авсан. Төсвийн үндсэн тэнцэл 2016 онд 17% алдагдалтай байсныг 2018 онд 3%-ийн ашигтай болгож, ДНБ-ий 20 орчим хувьтай тэнцэх хэмжээний төсвийн томоохон нэгтгэлийг хийж чадсан. Энэ нь тухайн үеийн ОУВС-гийн хамгийн үр дүнтэй хөтөлбөрүүдийн нэг байсан. Засгийн газар үр ашиг муутай зардлыг ихээр танаж (жишээлбэл, Хөгжлийн банкны том багц), төрийн албан хаагчдын цалингийн зардлыг царцааж, донорын бус санхүүжилттэй дэд бүтцийн төслүүдийг түр зогсоож, нийгмийн хамгааллын гол хөтөлбөрийг үргэлжлүүлэхийн зэрэгцээ зарим албан татварыг нэмсэн. Түүхий эдийн үнэ өндөр байсан, экспортын орлого их хэмжээгээр нэмэгдсэн, ГШХО сэргэсэн зэрэг нь уг тохируулгын алхмуудыг хөнгөвчилж өгсөн. Гэвч төсвийн энэхүү хянамгай байдал нь хөтөлбөр дуусгавар болсны дараа, мөн 2020 оны сонгуулийн дараа хадгалагдах эсэх нь тодорхой бус байна.

Макро эдийн засгийн эдгээр үр дүнг тус улсын институцийн онцлогийн үүднээс харах хэрэгтэй. Монголбанкны үйл ажиллагааг хараат бус гэж үздэг ч, бодит байдал дээр түүний үйл ажиллагаанд улс төрчид, Засгийн газар хөндлөнгөөс нөлөөлөх эрсдэл өндөр байдаг. Монголбанкны Ерөнхийлөгч 6 жилийн хугацаатай томилогддог боловч дунджаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх хугацааныхаа талаас дээш хугацаа өнгөрөхөд төв банкны ерөнхийлөгч өөрчлөгдөж байна. Мөнгөний бодлогын эрх бүхий байгууллага өрийн урхи гэх асуудалтай тулгарч байна. Энэ нь нэг талаас өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд төгрөгийн ханшийн сулралтыг макро эдийн засгийн орчинтой нь нийцтэйгээр хүлээн зөвшөөрөх шаардлагатай боловч нөгөө талаас ам.доллараар илэрхийлэгдэх их хэмжээний гадаад өртэй байгаа нь төгрөгийн ханш сулралтын хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг хязгаарлаж байна. Олон улсын өнөөгийн түвшинтэй харьцуулахад инфляци 7 орчим хувьтай

байгаа нь маш өндөр бөгөөд Монголбанк ер бусын өндөр инфляцийн зорилтот түвшин болох 8 хувьд барихыг зорьж байна. Долларжилт харьцангуй бага, М2 мөнгөний нийлүүлэлтийн 16 хувь орчимтой тэнцэж буй бөгөөд заримдаа хар зах дээр ханш үе үе, бага зэрэг хазайдаг.

Монгол Улсын санхүүгийн салбар төдийлөн сайн төрөлжөөгүй тул мөнгөний бодлогын үйл ажиллагаа явуулахад сорилт тулгардаг. Хэдийгээр “банкны үйлчилгээний хүртээмж” өндөр боловч урт хугацааны санхүүжилт бага байдаг бөгөөд валютын ханшийн эрсдэлээс хамгаалах цөөн тооны хэрэгсэл байдаг. Мөн санхүүгийн салбар хэт төвлөрсөн, хамгийн том гурван банк салбарын активын гуравны хоёрыг бүрдүүлдэг. Иймд банкны системийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж бэхжүүлэх, засаглалыг сайжруулах, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх нь чухал болно. Гадаадын банкуудын тухайд БНХАУ-ын төрийн өмчит банкнаас бусад гадаадын банкинд Монгол Улсад банкны бүрэн үйлчилгээний зөвшөөрөл авах сонирхол одоогоор байхгүй байна. Гадаадын цөөхөн хэдэн банкны төлөөлөгчийн газар Монголд байдаг. Эдгээр нь маш хязгаарлагдмал хүрээнд ажилладаг бөгөөд өөрсдөө банкны үйлчилгээ үзүүлдэггүй. Монголд бизнес эрхэлж буй гадаадын компаниудын зардал нэмэгддэг (жишээлбэл, тус улс дахь БНХАУ-ын 7000 орчим бизнес эрхлэгчдийн хувьд). Хувийн салбарын өрийн менежментийн хүрээнд өрийг компанийн хувь эзэмшлээр своп хийж солих замаар хэсэгчлэн хэрэгжүүлэх хувилбар байж болох хэдий ч, энэ нь зөвхөн арилжааны таатай нөхцөл, төрийн зохистой бодлого бүрэлдсэн үед хэрэгжих боломжтой юм. Үнэндээ, сүүлийн жилүүдэд хийсэн хэлцэл хувь эзэмшлийг өрөөр солих буюу эсрэг чиглэлд явагдаж, өрийн асуудлыг улам даамжруулсан.

## **Худалдаа, гадаадын хөрөнгө оруулалт**

Монгол улсын олон улсын худалдааны харилцаанд гурван онцлог хүчин зүйлс давамгайлдаг. Нэгдүгээрт, 1990-ээд он хүртэл хаалттай бөгөөд ЗХУ-аас хамааралтай байсан эдийн засгийг хурдтай нээсэн явдал. Хоёрдугаарт, төлбөрийн тэнцлийн өвөрмөц бүтэц бөгөөд үүнд маш их хэмжээний урсгал дансны алдагдал, түүнтэй зэрэгцэх их хэмжээний хөрөнгийн дотогшлох урсгал зэрэг орно. Гуравдугаарт, экспортын бараа бүтээгдэхүүн болон зах зээлийн хувьд өндөр төвлөрөл бүхий экспортын өрөөсгөл бүтэц юм. Эдгээр гурван онцлог хүчин зүйлсийг энэхүү хэсэгт хураангуйлж, 3-р бүлэгт илүү нарийвчлан тусгасан болно.

Монгол Улс нь газарзүйн алслагдмал байдлаас үүдэлтэй худалдааны өндөр өртөг, зардалтай хэдий ч, маш нээлттэй эдийн засагтай улс юм. Барааны нийт гадаад худалдааны эргэлт ДНБ-ий 116%-тай тэнцдэг. Дундаж тариф нь 5.5%

бөгөөд үүнээс төдийлөн хазайдаггүй. Монгол Улс тарифын бус хэрэгслүүдийг мөн төдийлөн хэрэглэдэггүй. Тус улс нь цорын ганц бүрэн хэмжээний хөнгөлөлттэй нөхцөлтэй худалдааны хэлэлцээр хийсэн нь Япон улстай байгуулсан “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр” юм. Цаашилбал, тус улс дараах хэд хэдэн хоёр талт хэлэлцээртэй байна. Үүнд: БНХАУ-тай байгуулсан “Иж бүрэн стратегийн түншлэлийн хэлэлцээр”, ОХУ-тай байгуулсан “Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай гэрээ”, АНУ-тай байгуулсан “Стратегийн түншлэлийн хэлэлцээр” тус тус орно. Хилийн саадгүй чөлөөт худалдааны бүсийг голчлон БНХАУ-тай алгуур хөгжүүлж байна. Монгол Улсын тариф бага тул чөлөөт бүсүүдийн давуу талууд нь хил дамнасан худалдаа, ложистикийг үр ашигтайгаар хангах, хилийн цаадах худалдааны саадыг багасгахад оршино. Энэхүү нээлттэй худалдааны дэглэмд үл хамаарах гол бүтээгдэхүүнд улаан буудай, самар зэрэг хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүн орно. Улаан буудайн үнийг хамгаалснаар талх, гоймонгийн бүтээгдэхүүний үнийг өсгөдөг тул тэгш байдалд хамгийн хор уршигтай нөлөө дагуулдаг.

Хүснэгт 1.4-т эдийн засгийн шилжилтийн үе (1995 оныг сонгосон), 2010 оны уул уурхайн эрчимтэй өсөлтийн үе, эдийн засгийн хамгийн саяхны хүндрэлтэй үе болох 2017 он тус бүрээр Монгол Улсын төлбөрийн тэнцлийг задлан харуулсан болно. Ерөнхийлөн дүгнэвэл, (i) Монгол Улс олон улстай холбогдохын хэрээр төлбөрийн тэнцэл огцом тэлж байна; (ii) төсвийн алдагдал анх хөгжлийн албан ёсны тусламжаар санхүүжиж байсан учир 1990-ээд оны дунд үеийн урсгал данс багахан ашигтай байсан бол 2000 оноос хойш ихэвчлэн гадаадын шууд хөрөнгө оруулалт, зээлийн багц болон бусад хөрөнгө оруулалтын урсгалаар түлхүү санхүүжсэн; (iii) Төв Азийн зарим орнуудтай харьцуулсан Монгол Улсын мөнгөн гуйвуулга зэргийг онцлохуйц байна. Худалдааны тэнцэл гол төлөв уул уурхайн экспортын орлогоос хамаарч ашигтай буюу алдагдалтай байсан. Жишээлбэл, 2010 онд импорт хурдацтай өсч байсан (зарим талаар уул уурхайн өсөлтийг дагаж) тул худалдааны тэнцэл алдагдалтай гарсан бол 2017 онд эдийн засгийн уналтаас үүдэн импортын хэмжээ буурч, экспортын бүтээгдэхүүний үнэ уналтаас сэргэж эхэлсэн тул ашигтай гарч байсан. Үйлчилгээний худалдааны тэнцэл байнга алдагдалтай гардаг бөгөөд аялал жуулчлал эрчимтэй хөгжих, эсвэл Монгол Улсын бусад үйлчилгээний салбар өрсөлдөх чадвартай болж чадвал энэхүү байдал өөрчлөгдөж болох юм.

Шилжилтийн үед үйлдвэрлэлийн салбарын бараа бүтээгдэхүүн нийт экспортын тал хүртэлх хувийг эзэлж байсан. Гэвч хуучин төвлөрсөн төлөвлөгөөт үеийн хөнгөн үйлдвэрүүд хаагдаж, Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний олон талт худалдааны хэлэлцээр дуусгавар болсноор тус улсын олон улсын бэлэн хувцасны зах зээлд нэвтрэх хөнгөлөлт зогсч, уул уурхайн бүтээгдэхүүний экспорт хурдацтай өсч эхэлснээр энэ нь огцом буурсан (Зураг 1.10). 2010


оноос хойш үйлдвэрлэлийн салбар нь ерөнхийдөө нийт экспортын 20%-иас бага байсан бөгөөд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт маш бага хэмжээтэй байв. Монгол Улс уул уурхайгаас хараат эдийн засагтай болсноос хойш энэ салбар ерөнхийдөө бараа бүтээгдэхүүний экспортын 70-аас доошгүй хувийг бүрдүүлж ирсэн бөгөөд зарим жилүүдэд 90%-д хүрч байсан удаатай. Үйлчилгээний экспорт нь барааны экспортоос үргэлж бага байсан бөгөөд сүүлийн жилүүдэд экспортын 15-аас хэтрэхгүй хувийг бүрдүүлж байна.

#### Хүснэгт 1.4: Төлбөрийн тэнцэл, 1995, 2010, 2017 он (сая ам.доллар)

Төлбөрийн тэнцлийн үзүүлэлт	1995	2010	2017
Худалдааны тэнцэл	25	-172	1,490
Барааны экспорт	451	2,908	5,834
Зэс	269	771	1,613
Алт	49	178	595
Барааны импорт	426	3,080	4,345
Үйлчилгээний тэнцэл	-38	-303	-1,212
Үйлчилгээний экспорт	57	486	966
Үйлчилгээний импорт	95	789	2,178
Цэвэр анхдагч орлого	-25	-598	-1,613
Мөнгөн гуйвуулга	0	18	63
Цэвэр хоёрдогч орлого	77	187	180
Мөнгөн гуйвуулга	0	248	211
Урсгал дансны тэнцэл	39	-885	-1,155
Хөрөнгө, санхүүгийн данс	50	-643	-1,056
Хөрөнгийн данс	0	152	78
Хөрөнгийн шилжүүлэг	0	153	78
Бусад хөрөнгө	0	-1	0
ГШХО	10	1,629	1,446
ХАЁТ	209	303	764

ГШХО = гадаадын шууд хөрөнгө оруулалт, ХАЁТ = хөгжлийн албан ёсны тусламж.  
Эх сурвалж: Монголбанк. <https://www.mongolbank.mn/eng/> (2019 оны 3-р сарын байдлаар).

Зураг 1.10: Бараа, үйлчилгээний экспорт, 1996–2018 он




Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо. <http://www.en.nso.mn/index.php> (2019 оны 3-р сарын байдлаар).

Зураг 1.11-д хөрөнгийн урсгалын гол гурван суваг болох ГШХО, хөгжлийн албан ёсны зээл тусламж болон мөнгөн гуйвуулга зэргийг ДНБ-д эзлэх хувиар харьцуулсан болно. Бага-дунд орлоготой шилжилтийн эдийн засагтай орнуудаас Монгол Улсын ялгагдах байдал нь 2000 оноос хойш тус улсын олон улсын хөрөнгийн урсгалд гадаадын шууд хөрөнгө оруулалт давамгайлж ирсэн явдал юм. Хөгжлийн албан ёсны тусламж нь 1990-ээд оноос 2004 он хүртэлх хугацаанд эдгээр гурваас хамгийн их бөгөөд тогтвортой хөрөнгийн урсгал байсан юм. Тэр үеэс хойш 2009, 2017 оны хямралын жилүүдэд бага зэрэг нэмэгдсэнийг эс тооцвол мөнгөн гуйвуулга үнэмлэхүй утгаараа (мэдээж харьцангуй) буурч ирсэн байна. Шилжилтийн зарим жилүүдэд мөнгөн гуйвуулгын хэмжээ ГШХО-тай тэнцэж байсан тохиолдол бий хэдий ч 2000 оны эхэн үеэс бага байсаар ирсэн.

ГШХО нь 2008 оноос хойшхи уул уурхайн эрчимтэй өсөлтийн жилүүдэд давамгайлж байсан боловч 2013 оноос хойш огцом буурсан бөгөөд дээр дурьдсанчлан, 2016 онд Рио Тинто хувь эзэмшлээ өрийн хэрэгсэлд хөрвүүлснээс үүдэн маш их хэмжээний хөрөнгийн гадагшлах урсгал үүссэн.

**Зураг 1.11: Гадаадын шууд хөрөнгө оруулалт ба хөгжлийн албан ёсны тусламж, 2001–2017 он**



ГШХО = гадаадын шууд хөрөнгө оруулалт, ХАЁТ = хөгжлийн албан ёсны тусламж.

Эх сурвалж: Дэлхийн банк, Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүдийн мэдээллийн сан. <https://databank.worldbank.org/source/world-development-indicators> (2019 оны 3-р сарын байдлаар).

## Нийгмийн үзүүлэлтүүд

Монгол Улсын амьжиргааны түвшинг үндсэндээ нэг хүнд ногдох орлогоор тодорхойлдог боловч нийгмийн үзүүлэлтүүд нь тухайн улсын түүх, эдийн засгийн бүтцээс хамааралтай байдаг. Наймдугаар бүлэгт дурдсанчлан, эдийн засгийн шилжилтийн үед тус улс нь бага орлоготой, тэгш эрхт хөгжлийн загвартай, төрөөс үхэх хүртэл нийгмийн халамжтай, баталгаат ажлын байртай, цаг уурын гамшгаас бусад үед малын тоо толгой ихтэй, хагас нүүдэлчин эдийн засагтай байсан. Тэр үед бүх нийтээр бичиг үсэг тайлагдсан, хүйсийн ялгаа бага байсан. Зах зээлийн эдийн засагт шилжсэнээр төрийн халамжийг хадгалах төсвийн чадвар, тэгш эрхт хөгжлийн загвар хоёулаа доройтсон. Амьжиргааны түвшин эдийн засгийн өсөлтөө даган өөрчлөгдөх болсон. Боловсролын төлөөх зорилт хүчтэй хэвээр, төрийн нийгмийн халамжийн элементүүд өөрчлөгдөлгүй хадгалагдсаар байна.

Хүснэгт 1.5-д шилжилтийн эдийн засагтай дөрвөн улсуудын коммунизмын төгсгөл үеийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг харьцуулан харуулсан болно. Монгол Улс нэг хүнд ногдох орлогын түвшингээр хоёрдугаарт бичигдсэн боловч боловсролд хамруулах жил, дундаж наслалтаараа Казахстан, Бүгд Найрамдах Киргиз улсаас хоцорсон бөгөөд нялхсын эндэгдлийн түвшин өндөр байна. Монгол Улс эдгээр үзүүлэлтүүдээр БНАЛАУ

(мөн Вьетнамаас бусад Зүүн өмнөд Азийн ядуу буурай орнууд)-аас нэлээд түрүүлж байна. Монгол Улсын хүйсийн ялгаа харьцангуй бага байна. Харин Монгол эмэгтэйчүүд бусад орны эмэгтэйчүүдээс өндөр боловсролтой боловч дундаж наслалт доогуур түвшинд байна.

**Хүснэгт 1.5: Нийгэм, эдийн засгийн үзүүлэлт, Монгол Улс,  
Казахстан Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс,  
Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, 1990 он**

Үзүүлэлт	Казахстан Улс	Бүгд Найрамдах Киргиз Улс	БНАЛАУ	Монгол Улс
Нэг хүнд ногдох ДНБ (нэрлэсэн \$)	1,647	609	203	1,172
Хүн ам (сая)	16.5	4.4	4.3	2.2
Экспорт, импорт (ДНБ-нд эзлэх хувь) <sup>a</sup>	149.3	78.8	35.8	58.6
Сургуульд хамрагдах жил	8.1	8.6	3.1	7.7
Эрэгтэй	8.6	9.1	4.3	8.0
Эмэгтэй	7.6	8.1	1.9	7.4
Дундаж наслалт	66.8	66.3	53.6	60.3
Эрэгтэй	61.8	62.3	52.3	57.8
Эмэгтэй	71.5	70.2	54.9	62.9
Нялхсын эндэгдэл (1000 амьд төрөлтөд)	44	54	111	77
Мөнгөн гуйвуулга, ДНБ-ий хувиар <sup>b</sup>	0.6	0.1	1.3	0.5
ХХИ-д эзлэх байр	53	76	118	86
ХХИ-д эзлэх байр-нэг хүнд ногдох ДНБ-ээр эзлэх байр	10	-23	0	0

ДНБ = дотоодын нийт бүтээгдэхүүн, ХХИ = Хүний хөгжлийн индекс, БНАЛАУ = Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Улс.

<sup>a</sup> Казахстан 1992, бусад нь 1990 он

<sup>b</sup> Казахстан 1992, Бүгд Найрамдах Киргиз улс 1993, БНАЛАУ 1990, Монгол Улс 1998 он  
Эх сурвалж: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүний хөгжлийн мэдээлэл (1990 - 2017), <http://hdr.undp.org/en/data>; Дэлхийн банк, Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүдийн мэдээллийн сан. <https://databank.worldbank.org/source/world-development-indicators> (2019 оны 3-р сарын байдлаар)

Дөрвөн орны жагсаалтад эзлэх байр 1990 оноос хойш бараг өөрчлөгдөөгүй боловч тэдгээрийн бүх нийгмийн үзүүлэлтүүд эрс сайжирсан (Хүснэгт 1.6). Монгол Улсын хувьд дундаж наслалт 9 жилээр, ерөнхий боловсрол 2 жилээр тус тус нэмэгдсэн. Нялхсын эндэгдэл 1990 оны түвшний ердөө тавны нэгтэй тэнцэж байна. Монголын иргэд шилжилтийн үеийн хүнд хэцүү үеийг туулсан хэдий ч одоо ерөнхийдөө амьдралын түвшин харьцангуй дээрдсэн байна.<sup>17</sup> Харин хүйсийн ялгааны хувьд дордсон байна, үүнд: эрүүл мэнд, боловсролын үзүүлэлтүүдийн аль аль нь хамаарч байна (дээд боловсролын түвшинд

<sup>17</sup> Бохирдолттой холбоотой амьсгалын замын өвчлөл Улаанбаатарт нэмэгдэж байгаа гэх зэргээр Монгол Улсад эрүүл мэндэд ноцтой бэрхшээл тулгарсан хэвээр байна.



эмэгтэйчүүдийн хамралт эрэгтэйчүүдээс өндөр байгаа хэдий ч). Бусад үзүүлэлтэд жендэрийн холимог үр дүн харагдаж байна. Жишээлбэл, Монгол Улс НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Жендэрийн тэгш бус байдлын индекс нэлээд дээгүүр жагсдаг боловч эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин бага байна.

### Хүснэгт 1.6: Нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд, Монгол Улс, Казахстан Улс, Киргиз Улс, Бүгд Найрамдах Лаос Ард Улс, 2017 он

Үзүүлэлт	Казахстан Улс	Бүгд Найрамдах Киргиз Улс	БНАЛАУ	Монгол Улс
Нэг хүнд ногдох ДНБ (нэрлэсэн \$)	9,030	1,220	2,457	3,717
Хүн ам (сая)	18.2	6.0	6.9	3.1
Экспорт, импорт (ДНБ-нд эзлэх хувь)	0.0	102.2	75.8	116.6
Сургуульд хамрагдах жил	11.8	10.9	5.2	10.1
Эрэгтэй	11.7	10.8	5.7	9.8
Эмэгтэй	11.8	10.9	4.6	10.6
Дундаж наслалт	70.0	71.1	67.0	69.5
Эрэгтэй	65.3	67.1	65.4	65.4
Эмэгтэй	74.8	75.1	68.6	73.7
Нялхсын эндэгдэл (1000 амьд төрөлтөд)	9	18	49	15
Мөнгөн гуйвуулга, ДНБ-ий хувиар	0.2	32.9	1.5	2.4
ХХИ-д эзлэх байр	58	122	139	92
ХХИ-д эзлэх байр-нэг хүнд ногдох ДНБ-ээр эзлэх байр	4	-26	15	-2


ДНБ = дотоодын нийт бүтээгдэхүүн, ХХИ = Хүний хөгжлийн индекс, БНАЛАУ = Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс. Эх сурвалж: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүний хөгжлийн мэдээлэл (1990–2017), <http://hdr.undp.org/en/data>; Дэлхийн Банк, Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүдийн мэдээллийн сан. <https://databank.worldbank.org/source/world-development-indicators> (хоёулаа 2019 оны 3-р сарын байдлаар)

Ядуурлын түвшин эдийн засгийн өсөлтийг даган өөрчлөгдөж ирсэн (Зураг 1.12). Жилээр болон олон улстай харьцуулалт хийх боломжтой болгох үүднээс Дэлхийн Банкнаас гаргасан өдөрт 1.90 ба 3.20 ам.долларын ядуурлын шугам (2011 онд худалдан авах чадварын паритетэд суурилсан үнээр)-ыг ашигласан болно.<sup>18</sup> Ядуу иргэдийг хоёр цувралаар тооцоолоход 1990-ээд оны үед өсч, дараа нь эдийн засгийн өсөлт эхлэхтэй зэрэгцэн огцом буурсан ижил төстэй чиг хандлага ажиглагдсан. 1.90 ам.долларын цувралыг “хоосролын” хэмжигдэхүүн

<sup>18</sup> Дэлхийн Банкны мэдээллийг 8-р бүлэгт дурдсан. Учир нь, Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан ядуурлын статистикт хүн амын ядуурал 1995 онд 36.3% байсан бол 2016 онд 26.9% болж харьцангуй бага бууралт харуулж байна. Орлогын хэмжээ мэдэгдэхүйц өсөж, албан ёсны Жини тэгш бус байдлын харьцаа харьцангуй тогтворжсон тул статистикийн газар ядуурлын шугамыг дээшлүүлж, хугацааны харьцуулалт хийх боломжийг хязгаарласан байна.

гэж нэрлэдэг бөгөөд Монгол дахь нэн ядуурал энэ хэмжигдэхүүнээр бараг арилсан байгаа бол “дунд орлоготой” цуврал (3.20 ам.доллар)-ын ядуурлын түвшин 5 орчим хувьтай байна. Энэ хэмжигдэхүүнээр тооцоолоход 1990-ээд оны сүүлчээр ядуурал 60-аас дээш хувьтай байсан гэхэд энэ нь үнэхээр гайхалтай амжилт юм. Эдийн засгийн хямрал нүүрлэсэн 2016 онд энэ хоёр цуврал бага зэрэг өссөн нь нийгмийн хамгааллын зорилтот арга хэмжээ үр дүнтэй байгааг илтгэж байна. Жини индексээрх зарлага нь 1990-ээд оны дунд үеэс 0.30-аас 0.35 хооронд хэлбэлзэж, харьцангуй тогтворжсон гэх дүгнэлт нь Монгол Улсад тэгш бус байдал нэмэгдэж байгаа гэх ойлголттой зарим талаар зөрчилдөж байна. Монгол Улсын иргэд олон улсын судалгаа (Gallup Poll гэх мэт)-нд хамрагдаж, хэр аз жаргалтай, амьдралдаа сэтгэл ханамжтай байгаа талаар хариулсан байдал нь нэг хүнд ногдох орлоготойгоо төстэй байна. 8-р бүлэгт ядуурал, орлогын хуваарилалтын чиг хандлагыг үндэсний ядуурлын шугамтай харьцуулан нарийвчлан судалсан болно. Ядуурлын тооцоонд ерөнхийдөө нийтлэг, ижил мэдээллийн эх үүсвэр (өөрөөр хэлбэл, үндэсний орлого, зарлагын судалгаа)-ийг ашигладаг боловч олон улсын болон дотоодын ядуурлын түвшний тооцоонд хоёр өөр мэдээллийн эх үүсвэр бүхий ядуурлын шугамыг ашигладаг тул ихэвчлэн хоорондоо ялгаатай байдаг.

**Зураг 1.12: Ядуурал ба тэгш бус байдлын үзүүлэлтүүд, 1991–2017 он**



ХАЧП = худалдан авах чадварын паритет.

Эх сурвалж: Дэлхийн Банк, Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүдийн мэдээллийн сан. <https://databank.worldbank.org/source/world-development-indicators> (2019 оны 3-р сарын байдлаар).

### 1.3 Дүгнэлт ба бодлогын зөвлөмж

Монгол Улс их замын уулзвар дээр байна. Тус улс нь 1990 онд улс төр, эдийн засгийн шилжилтийг эхлүүлснээс хойш томоохон амжилтад хүрсэн. Эдийн засгийн гүн хямрал, нийгмийн асуудалтай хүнд хэцүү арван жилийн нүүрийг үзсэний дараа эдийн засаг аажмаар сэргэж, 2000-аад оны эхээр нэг хүнд ногдох ДНБ (мөн нийгэм эдийн засгийн ихэнх үзүүлэлтүүд) шилжилтийн өмнөх түвшинд хүрсэн нь зарим нэг шилжилтийн эдийн засагтай улсуудтай харьцуулахад түүхэн амжилт юм. Монгол Улс өргөн уудам, хүн ам сийрэг суурьшсан газар нутгийнхаа бүрэн бүтэн байдлыг хадгалсаар ирсэн бөгөөд хөрш орнуудтайгаа эв найрамдалтай харилцаатай байна. Мөн тус улс нь дэлхийн хамгийн динамик бүс нутгуудтай зэргэлдээ орших нээлттэй эдийн засагтай орон юм. Түүнчлэн асар их эрдэс баялагтай улс бөгөөд хөдөө аж ахуйн түүхэн давуу талаас гадна уул уурхайн бус хэд хэдэн салбарт хөгжих ирээдүйтэй. Монголын ихэнх иргэд өндөр боловсролтой, иргэний нийгэм нь эрч хүчтэй, хэвлэл мэдээлэл нээлттэй, мөн тайван замаар төрийн эрхийг шилжүүлэх зэргээр ардчилсан үйл явцаа хадгалсаар ирсэн.

Гэсэн хэдий ч Монгол Улсын эдийн засгийн үзүүлэлт улам бүр сайжирч болохоор, сайжрах ч ёстой байсан. Хуримтлалын механизм болон түүний хэрэгжилт байхгүй, үр ашиггүй зарцуулалт ихтэй, татвар болон зохицуулалтын орчин төдийлөн оновчтой биш, мөн эдийн засгийн үр ашиггүй төсвийн хөрөнгө оруулалттай болоод авлигын түвшин зэргээс шалтгаалан тус улс арвин их байгалийн баялгаа оновчтой ашиглаж чадалгүй өдийг хүрсэн. Макро эдийн засгийн бодлогын хүрээ нь гадны томоохон цочролыг зохицуулах хэмжээнд хөгжиж чадаагүйгээс тэлэлт-агшилтын мөчлөг бүхий өсөлтөд хүргэж, эдийн засгийн хямралыг давахын тулд олон улсын хөтөлбөрт тогтмол хамрагдаж ирсэн. Хувийн болон төрийн секторын өрийн хэмжээ их учраас дэлхийн эдийн засгийн цочролд, түүний дотор хүүгийн өсөлт, валютын ханшийн хэлбэлзэлд өртөмтгий болж байна. Макро эдийн засгийн хүчин зүйлс (ялангуяа валютын ханшийн удирдлага), мөн уул уурхайн бус салбаруудад жижиг хэмжээний, тохиолдлын шинжтэй дотоодын хөрөнгө оруулалт хийж, бизнесийн орчныг шинэчлэх явц удаашралтай байснаас үүдэн эдийн засгийн төрөлжилт удаан явагдаж байна. Мөн уул уурхайн үр өгөөжийг тэгш хуваарилалгүй ирсэн. Эдийн засгийн хурдацтай өсөлттэй үед нийгмийн хамгааллын зардал хурдан өссөн ч тогтворгүй түвшинд хүрснээс гадна зорилтот бүлэгт оновчтой чиглэгдээгүй. Түүнчлэн хот, хөдөө орон нутагт байгаль орчны дарамт нэмэгдэж байна. Хамгийн чухал нь 1990-ээд оны эхэн үеэс хойш бий болгосон ардчиллын магтууштай ололт амжилтаа хөгжилд чиглэсэн хүчирхэг институцийг бий болгох замаар засаглалаа сайжруулан бататгах хэрэгтэй хэвээр байна.

Оношлогооны судалгааны энэхүү бүлэг болон бусад долоон бүлгээс дараах бодлогын зөвлөмжийг дэвшүүлсэн болно.

## **Макро эдийн засгийн бодлого**

**Ирээдүйд тэлэлт-агшилтын мөчлөгийг зогсоох үүднээс төсвийн бодлогыг тогтвортой байдлын зорилтуудад чиглүүлэх.** Үүний тулд, 2010 онд батлагдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болоод түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтөд нийцсэн төсвийн хүрээг хэрэгжүүлэх шаардлагатай. Тус хуульд баримтлах шаардлагатай өрийн дээд хязгаар, тэнцвэржүүлсэн тэнцэл, зардлын өсөлтийг аль хэдийн тусгасан байдаг. Засгийн газрын өр зохих босгоноос доош орж, өндөр хүүтэй үлдэгдэл өрийг төлсний дараа Ирээдүйн өв санд үргэлжлүүлэн хөрөнгө төвлөрүүлж, хуримтлуулах хэрэгтэй.

**Төсвийн нэгдмэл байдал, сахилга бат болон төсвийн идэвхтэй удирдлагыг үргэлжлүүлэн явуулах.** Монгол Улс ОУВС-гийн хөтөлбөрийг хэрэгжүүлж дуусахад УИХ-аас төсвөөс гадуурх зардлыг нэмэгдүүлэх цар хүрээг үр дүнтэй хязгаарлах шаардлагатай. Төсвөөс гадуур шинэ санг байгуулах ёсгүй. Төсвийн төлөвлөлт, урьдчилсан тооцоог илүү бодитой болгох нь зүйтэй. Батлагдсан төсөв болон төсвийн гүйцэтгэл хоорондын зөрүүг хамгийн бага түвшинд байлгахын тулд төсвийг зохих ёсоор зарцуулах ёстой. Төсвийн зарцуулалт, төсвийн төсөөллийг нарийвчлан хянаж, төсвийн бүрэн ил тод байдлыг хангах нь шийдвэрлэх ёстой чухал асуудал юм. Дотоодын хөрөнгө оруулалтыг өргөн хэрэглээний барааны нийлүүлэлтийн тасалдлыг бууруулах, эдийн засгийн бүтцийн асуудлыг шийдвэрлэх, мөнгөний бодлогын орон зай, уян хатан байдлыг нэмэгдүүлэх үүднээс зах зээлийн гажуудлыг багасгахад тус тус чиглүүлэх нь зүйтэй.

**Мөнгөний болон валютын ханшийн бодлогыг бэхжүүлэх.** Өнөөгийн тохируулгын хөтөлбөрөөс гадна дараагийн нэг тулгамдсан асуудал нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ хэрэглээний үнийн индексийг тогворжуулах, инфляцийг бууруулах явдал юм. Түүнчлэн, мөнгөний бодлогыг төсвийн бодлоготой зөв уялдуулан хэрэгжүүлбэл эдийн засаг, ажил эрхлэлтэд гарч буй хүчтэй цочролыг багасгахад чухал үүрэг гүйцэтгэх боломжтой. Инфляцийг онилох дэглэмд шилжих асуудал нь Монголбанкны загварчлалын дотоод чадавхийг мэдэгдэхүйц сайжруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зэрэг олон угтвар нөхцөлийг хангахыг шаардана.

**Дараагийн уналтад илүү сайн бэлтгэх зорилгоор гадаад валютын нөөцийг макро эдийн засгийн зорилттой уялдуулан нэмэгдүүлэх.** Валютын нөөцийг боломжийн хэрээр зах зээлийг гажуудуулалгүйгээр нэмэгдүүлэх ёстой бөгөөд энэ нь макро эдийн засгийн бодлогын зорилттой нийцэж байх ёстой. Валютын ханшийн уян хатан байдал, гадаад валютын хангалттай нөөц болон цочролд бодлогын эрт хариу арга хэмжээ авах замаар эдийн засгийн гадаад цочролыг илүү сайн шингээж авах боломжтой.

**Макро зохистой бодлогыг бэхжүүлэх.** Энэ нь санхүүгийн тогтолцоонд бүхэлд нь мөчлөг сөрсөн тогтворжилтыг бий болгоход нэн шаардлагатай. Жишээлбэл, эдийн засгийн мөчлөгөөс хамааран өөрийн хөрөнгө буюу эрсдэлийн сангийн нэмэлт шалгуур, шаардлагыг нэмэгдүүлэх зэрэг үүнд хамаарна. Банкуудын гадаад санхүүжилт нь эдийн засгийн мөчлөгтэй хамаарал өндөртэй байдаг тул банкуудын гадаадаас авах зээл, татан төвлөрүүлэх санхүүжилтэд тавих хяналт, мониторингийг сайжруулах хэрэгтэй.

**Банкны бодлого, зохицуулалтыг бэхжүүлж, хяналт шалгалтын чадавхийг сайжруулах.** Энэхүү хүчин чармайлт нь активын чанарын зохистой стандартыг тогтоон мөрдүүлэх, стресс тестийг тогтмол хэрэгжүүлэх, шаардлагатай бол өндөр чанартай өөрийн хөрөнгийг бүрдүүлэхэд онцгойлон чиглэгдэх ёстой. Банкуудын өөрийн хөрөнгийн зохистой харьцаа нь санхүүгийн системийн мөчлөгийн онцлог шинж чанартай уялдсан байх шаардлагатай бөгөөд өөрийн хөрөнгө нэмэгдэхийн хэрээр банкны өөрийн хөрөнгийн чанар сайжирч байх хэрэгтэй. Чанаргүй зээлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хямралаас урьдчилан сэргийлэх механизмын гол хэсэг гэж үзэх нь зүйтэй.

**Бүс нутгийн санхүүгийн салбарын хамгааллын сүлжээнд анхаарлаа хандуулж, санхүүгийн олон давхаргат хамгааллын сүлжээг бий болгох.** Чيانг Май санаачилга, АСЕАН + 3-ын Макро эдийн засгийн судалгааны алба, Азийн бондын зах зээлийн санаачилга зэрэг АСЕАН + 3 орны бүс нутгийн хямралын хариу арга хэмжээ<sup>19</sup> нь эрсдэлийг тодорхойлох, бууруулах, хариу арга хэмжээ авах чиглэлээр Монгол Улсыг бүс нутгийн санхүүгийн хамтын ажиллагаагаа бэхжүүлэх шаардлагатай байгааг тодотгож байна. Иймд Монгол Улс АСЕАН + 3 механизмтай ижил төстэй бүс нутгийн санхүүгийн салбарын хамгааллын системтэй болж, Чيانг Май санаачилгад нэгдэж, хөрөнгийн тогтворгүй урсгалын асуудлыг шийдвэрлэх зорилгоор бусад улсуудтай хоёр талт своп хэлцэл хийх нь чухал ач холбогдолтой юм.

<sup>19</sup> АСЕАН + 3-д Зүүн Өмнөд Азийн улсуудын холбооны гишүүн орнууд, мөн БНХАУ, Япон, БНСУ ордог.

## Байгалийн баялгийн менежмент

**Байгалийн баялгаас төсөвт орох орлогыг хойшлуулахаас зайлсхийх.** Хөгжиж буй орны хувьд Монгол Улсад хөрөнгө оруулалтын хэрэгцээ асар их байна. Гэсэн хэдий ч өрийн санхүүжилтээр дамжуулан төрийн хувьцаа эзэмших зэргээр уул уурхайн компаниудтай байгуулсан одоогийн гэрээнүүд нь ашгийн татвар хураан авч эхлэх хугацааг хойшлуулахад хүргэж байна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон бусад татварын хэрэгсэлд найдах нь илүү оновчтой стратеги юм.

**Уул уурхайн орлогыг жигдрүүлэх.** Мөчлөг дагасан уул уурхайн орлого нь өнгөрсөн хугацаанд төсвийн бодлогыг мөчлөг дагасан болгоход нөлөөлсөн. Тиймээс уул уурхайн орлогын илүү тогтвортой урсгалыг бий болгох нь төсвийн зардлыг жигд байлгахад тустай. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар гэх зэрэг түүхий эдийн үнээс эерэг хамааралтай орлогын эх үүсвэрт найдах гэхээс илүү ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр гэх мэт илүү тогтвортой орлогод түлхүү найдах нь зүйтэй юм.

**Орлогын төсөөллийг сайжруулах.** Засгийн газар уул уурхайн орлогын төсөөлөл тооцоолох чадавхаа сайжруулах хэрэгтэй. Мөн Сангийн яам, Монголбанк, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Үндэсний хөгжлийн газар, УИХ болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн орлогын тооцооллыг илүү сайн уялдуулах шаардлагатай байна. Орлого нь төлөвлөснөөс доогуур байвал алдагдлыг санхүүжүүлэхээс илүү төсвийн зардлыг бууруулдаг байх хэрэгтэй.

**Давхар татварын гэрээ, үнийн шилжүүлэг, төсөл хоорондын зааглалтыг сайжруулах.** Монгол Улс 26 улстай давхар татварын гэрээтэй бөгөөд ихэнх нь татвартай холбоотой хөнгөлөлт агуулдаг. Үнийн шилжүүлэг нь ашгийн татвар цуглуулахад тулгардаг бас нэг бэрхшээл юм. 2018 онд Монгол Улс Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага болон G20-ийн Татварын суурийг бууруулах, ашиг шилжүүлэхийн эсрэг санаачлага (BEPS)-д нэгдсэн нь татварын зохих орлогыг бүрдүүлэхэд чухал алхам болсон. Гэсэн хэдий ч засгийн газар BEPS-тэй холбоотой үүрэг хариуцлагаа эрчимжүүлж, татварын хууль тогтоомжид заасан үнийн шилжүүлэгтэй холбоотой хэсгийг тодорхой болгох хэрэгтэй.

**Тогтмол хуримтлалын механизмыг бий болгож, хэрэгжүүлэх.** Эдийн засгийн хурдтай өсөлт, түүхий эдийн үнийн өсөлттэй үед засгийн газрын өрийн удирдлага, өрийн үйлчилгээний бодлогын дагуу Төсвийн тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв сан зэрэг янз бүрийн механизмд уул уурхайн орлогыг хуримтлуулж, удирдах (хөрөнгө оруулалт хийх) хэрэгтэй.

## Эдийн засгийг төрөлжүүлэх

**Төрөлжүүлэх чиглэлд урт хугацааны стратеги боловсруулах.** Эдийн засгийг бүтцийн хувьд төрөлжүүлэх нь бүтцийн шинжтэй савлагааг бууруулж, ажлын байр нэмэгдүүлэх боломжийг олгодог. Засгийн газар нь эдийн засгийн хувьд хэрэгжих боломжтой, уул уурхайн салбарын ирээдүйн хөгжилтэй уялдсан урт хугацааны төрөлжүүлэх стратеги боловсруулах хэрэгтэй.

**Одоо байгаа хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг сайжруулах.** Засгийн газар нь эдийн засгаа төрөлжүүлэх шаардлагатайг бүрэн ойлгож, урт хугацааны бодлогын хэд хэдэн баримт бичиг баталсан. Гэсэн хэдий ч хэрэгжилт сул, хяналт бараг байхгүй, мөн өмнөх бодлогоо бүрэн хэрэгжүүлж, үнэлэлгүйгээр шинэ бодлого баталдаг. Мөн бодлогын баримт бичгүүдэд зардал-үр ашгийн нарийвчилсан шинжилгээ урьдчилан хийдэггүй, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, жилийн төсөвт тусгах зэргээр санхүүжүүлэх арга механизмыг тогтвортой хэрэгжүүлдэггүй.

**Экспортын зардлыг бууруулах.** Холбогдох зардал хэт өндөр байдгаас олон компаниуд, ялангуяа жижиг аж ахуйн нэгжүүдэд гадаад зах зээлд нэвтрэхэд хүндрэлтэй байна. Иймд Засгийн газар хамгийн чухалд тооцогдох зах зээлүүдийг холбож өгөх салбар, нэгж байгуулж болно. Мөн компаниудад ялангуяа хэмжилзүйн болон хүнсний аюулгүй байдлын чиглэлээр олон улсад магадлан итгэмжлэгдсэн дотоод, гадаадын лабораторийн хямд үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

**Бизнесийн таатай орчныг бүрдүүлэх.** Засгийн газар нь бизнес, институцийн орчныг сайжруулах үүднээс татвар, гаалийн бүрдүүлэлт болон хил дамнасан худалдааг хөнгөвчлөхийг зорьж байна. Ирээдүйн бодлогыг хүнд суртал, төрийн анхан шатны үйлчилгээ авахад гардаг зардал, авлигыг бууруулахад чиглүүлэх ёстой.

**Уялдаа, зохицуулалтын дутагдлыг арилгах.** Бүх салбарын бизнес эрхлэгчид гадаад зах зээлд үр дүнтэй хүрч, хамтран ажиллах боломж хомс байгаа тул тэдгээрийн хоорондын уялдаа зохицуулалт сул байдаг. Иймд төрийн байгууллага нь мэдээлэл солилцох, эсвэл одоогийн болон ирээдүйн экспортлогчид харилцан холбоо барих платформоор хангах замаар уялдаа, зохицуулалтын сул талыг арилгахад гол үүрэг гүйцэтгэх боломжтой.

## Дэд бүтэц ба бүс нутгийн зах зээлтэй холбогдох асуудал

**Хамгийн ирээдүйтэй хөрөнгө оруулалтыг тодорхойлох.** Монгол Улсын тээврийн дэд бүтцийг сайжруулах цар хүрээ асар их боловч гадаад хүчин зүйлс болоод авто зам, төмөр замын төслүүдийн ашиглалтын удаан хугацаанаас хамаараад зардал-үр ашгийн шинжилгээ хийхэд хэцүү болдог. Засгийн газар нь төсвийн тэнцэл, гадаад өрийн тогтвортой түвшинг хадгалахын зэрэгцээ ирээдүйн хөрөнгө оруулалтыг эрэмбэлэх аргыг тодорхойлох ёстой. Сүүлийн үед авто замын засвар, арчлалт болон замын аюулгүй байдал зэрэг асуудалд илүү их анхаарал хандуулах болсон нь сайн бөгөөд үүнийг үргэлжлүүлэх хэрэгтэй. Түүнчлэн дэд бүтцийн үнэлгээ, менежментийн өндөр стандартыг хангаж, улмаар нэн тэргүүний ач холбогдол бүхий, сайн гүйцэтгэлтэй төслүүдэд хязгаарлагдмал санхүүжилтийн эх үүсвэрийг хуваарилах нь чухал юм. Энэ хүрээнд бусад улс оронд үр дүнтэй ашиглаж байсан энгийн квадрант хэлбэрийн зарим төслийн менежментийн хэрэгслийг ашиглаж болно.

**Агаарын тээврийн өрсөлдөөнийг дэмжих.** Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг ашиглалтад оруулснаар агаарын орон зайн нээлттэй бодлого баримтлах сайхан боломж гарах болно. МИАТ ХК-ийг хамгаалах асуудал нь нислэгийн тоог нэмэгдүүлэх, тийзний үнийг бууруулах замаар худалдаа, аялал жуулчлалыг хөгжүүлэхээс хамаагүй бага ач холбогдолтой.

**Эрчим хүчний салбарыг шинэчлэх.** Эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх, агаарын бохирдлыг бууруулах асуудлын тэнцвэрт байдлыг хангахад хэцүү шийдвэр гаргах шаардлагатай байна. Улаанбаатарын цахилгаан, дулааны хангамж хуучирсан, байгальд ээлгүй гурван цахилгаан станцаас хамааралтай хэвээр байгаа асуудлыг аль болох эрт шийдвэрлэх хэрэгтэй. Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг хөхиүлэн дэмжих үүднээс хатуу түлшний татаасыг зогсоох (ядуу иргэдийн нийгмийн халамжийг үүнтэй уялдуулан нэмэгдүүлэх) зэрэг үнийн тодорхой бодлого шаардлагатай байна.

**Цахилгаан хангамжийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх.** Энэ нь бүх салбарт, ялангуяа цахим хөгжилд зайлшгүй шаардлагатай юм. Интернетийн холболтын бодлого зөв замаар явж буй нь харагдаж байна.

## Худалдаа

**Экспортыг хөгжүүлэх стратегийг макро эдийн засгийн ерөнхий бодлогын салшгүй хэсэг болгох.** Монголбанкны инфляцийг 8%-д барих



одоогийн зорилт нь нэлээд өндөр түвшний инфляцийн зорилт тул Монголын эдийн засгийг дэлхийн эдийн засагтай интеграцчилах бодлогын зорилттой төдийлөн нийцэхгүй байна. Экспортыг, ялангуяа эрдэс баялгийн бус салбар (органик хүнс, ноолуур, мал аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээ, аялал жуулчлалын үйлчилгээ, сэргээгдэх эрчим хүч гэх мэт)-т дэмжих нь эдийн засгийн бодлогын чухал зорилт болох ёстой. Экспортыг нэмэгдүүлэхийн тулд холбогдох институцийн шинэчлэлийг дэмжиж, хууль эрх зүй, зохицуулалтын орчныг боловсронгуй болгож, мөн экспортын батлан даалт, санхүүжилтийн хөтөлбөрийг цаашид хөгжүүлэх хэрэгтэй.

**Худалдааны зардлыг бууруулж, худалдааны бодлогыг таамаглахуйц, ил тод болгох.** Тээвэр, ложистикийн зардал өндөр учраас худалдааны зардал мөн өндөр байна. Түүнчлэн давж заалдах журам, баримт бичиг бүрдүүлэх шаардлага, харилцан цахим мэдээлэл солилцох боломжгүй байдал зэргээр дүрэм, журам хэт төвөгтэй тул худалдаанд шаардлагагүй дарамт үүсэж байна. Засгийн газар эдгээр зардлыг бууруулахын тулд хатуу, зөөлөн дэд бүтэц, ложистикийг хөгжүүлж, бизнес эрхлэгчдэд тарифыг нэн тааламжтай нөхцөлөөс хэтрүүлэн нэмэгдүүлэхгүй байх нь зүйтэй. Учир нь ийнхүү нэмэгдүүлэх нь хэрэгцээгүй тодорхойгүй байдал үүсгэдэг.

**Худалдааны хөнгөлөлттэй хэлэлцээрийг сайтар судлах.** Худалдааны хөнгөлөлттэй хэлэлцээр хийхээр шийдэхдээ Засгийн газар эрсдэл, боломжийг бүрэн ойлгож, тэдгээрийн тэнцвэрийг олох хэрэгтэй. Худалдааны хөнгөлөлттэй хэлэлцээрүүд нь худалдааг идэвхжүүлж болох боловч зөвхөн богино хугацаанд эерэг нөлөө үзүүлэх хандлагатай бөгөөд олон талт болон нэг талт худалдааны сувагтай харьцуулахад өгөөж багатай байдаг. Цаашилбал, өндөр хөгжилтэй орнуудын зах зээлд нэвтрэх боломж нь бүтээгдэхүүний хатуу стандарт, түүний дотор ариун цэвэр, эрүүл ахуйн стандартыг хангасан эсэхээс их шалтгаалдаг.

**Мах, махан бүтээгдэхүүн болон ноолууран хувцас, гутал зэрэг мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний өсөлтийн боломжийг ашиглах.** Боловсруулсан хүнсний бүтээгдэхүүний экспортыг дэмжихийн тулд эхлээд үйлдвэрлэгчид, экспортлогчдоор олон улсын хүнсний аюулгүй байдлын стандартыг хангуулахад туслах институцийн механизмыг бий болгох шаардлагатай. Гадаадын хөрөнгө оруулалт, түүний дотор тэдний ноу-хау, технологийг татах нь мөн зайлшгүй шаардлагатай. Эдгээр салбарыг хамгийн түрүүнд байгаль орчны тогтвортой байдалд суурилсан байдлаар өргөжүүлэх ёстой.

**Үйлчилгээний худалдааг хөнгөвчлөх.** Эдийн засаг үйлчилгээ рүү шилжихийн хэрээр энэ салбарт нэмэлт худалдаа хийх өргөн боломжтой бөгөөд үйлчилгээний зарим салбарыг гадаадын өрсөлдөөнд нээлттэй болгох нь чанарыг нэмэгдүүлж, үнийг бууруулах боломжтой юм. Түүнчлэн, Монголын үйлчилгээ экспортлогчдод олон улсад өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх боломжийг мөн бий болгох юм.

## Институци ба засаглал

**Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах.** Авлигын эсрэг олон хэрэгслийг ашиглахгүй байна. Эдгээр хэрэгслийг ашиглахын тулд төрийн байгууллагууд, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, иргэдийн хөдөлгөөнийг чадавхжуулах бүх хүчин чармайлтаа дайчлах хэрэгтэй. Энэ нөхцөлд прокурорын бие даасан бүрэн эрхийг хангах нь нэн чухал юм.

**Сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх.** Засгийн газар саяхан нээлттэй дата, мэдээллийн бодлогыг хэрэгжүүлэх туршлагатай болсон тул Монголын Үндэсний Аудитын газрын чадавхийг нэмэгдүүлэх, бодит цагаар хандивын мэдээллийг тайлагнах гэх мэт иргэдийн оролцоотой, дижитал арга нэвтрүүлэх, мөн төрийн мэдээллийн санг нэгтгэх замаар сонгуулийн санхүүжилтийг нээлттэй болгож, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь зүйтэй.

**Шүүхийн тогтолцооны ардчилсан чанарыг бэхжүүлэх.** Энэ ажил нь улс төр, эдийн засгийн байгууллагуудад итгэх иргэдийн итгэлийг сэргээх, бизнес эрхлэгчдийн итгэлийг бэхжүүлэх гол түлхүүр болно. Ил тод, хараат бус, хянуур тэнцвэртэй өөрийгөө удирдах механизмыг сайжруулах замаар шүүхийн хараат бус болон хууль ёсны байдлыг бэхжүүлэх нь зүйтэй бөгөөд үүнд Шүүхийн ерөнхий зөвлөл болон Ёс зүйн хороо зэрэг хамаарна.

**Засгийн газраас лиценз, зөвшөөрөл олгох журмын ил тод, тодорхой байдлыг сайжруулах.** Үүнийг ялангуяа мэргэжлийн хяналт, гааль зэрэг тэргүүлэх ач холбогдолтой, өндөр эрсдэлтэй салбаруудад хэрэгжүүлэх шаардлагатай байна. Засгийн газар, бизнесийн холбоод лиценз, зөвшөөрөл олгохтой холбоотой хууль тогтоомж, бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх ёстой. Салбарын болон бизнесийн холбоод нь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, нийгэм, олон нийтийн оролцоо, мөн байгууллагын хариуцлага ба ёс зүйн чиглэлээр бизнесийн үйл ажиллагааг сайжруулахад санал санаачлагатай, манлайлагч байх ёстой.

## Нийгмийн салбарууд

**Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг өргөжүүлэх.** Үүнд чадварлаг ажилчид бэлтгэх техник болон мэргэжлийн боловсролын сургалт, ур чадвар баталгаажуулах механизм, бизнес эрхлэх ур чадварын сургалт, ажил мэргэжлийн талаарх зөвлөгөө, залуучууд, хөдөө орон нутгийн иргэд, нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд зориулсан технологи, мэдээллийн харилцааны сургалт зэрэг багтана.

**Хөдөлмөр эрхлэлтийн уян хатан хэлбэрийг дэмжих.** Хөдөлмөрийн зах зээлийн оролцоонд жендэрийн тэгш бус байдлыг бууруулахын тулд үүнийг албан ёсны салбарт хэрэгжүүлэх ёстой. Ажил эрхлэх уян хатан хэлбэртэй эхийн чөлөө, эцэг эхийн амралт руу шилжих, хүүхэд харах үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх, хүүхэд харах үйлчилгээнд уян хатан байдлаар хамрагдах, хүүхэд төрүүлсний дараа хөдөлмөрийн зах зээлд эргэж ирсэн эмэгтэйчүүд болон 40-өөс дээш насныханд чиглэсэн сургалтын хөтөлбөрүүд явуулах зэрэг үүнд багтаж болно.

**Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг нэгтгэх.** Заримдаа давхардсан тэтгэмж бүхий нийгмийн халамжийн олон хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зардал ихтэй бөгөөд ихэнхдээ үр ашиггүй байдаг. Нийгмийн халамжийн тогтолцооны зорилтот бүлэгт чиглэсэн байдлыг сайжруулах, салбарын төсвийн тогтвортой байдал, цочролын нөлөөг бууруулах үр нөлөөг дээшлүүлэхийн тулд хөтөлбөрүүдийг дахин боловсруулж, оновчтой болгох хэрэгтэй. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд нийгмийн халамжийн тэтгэмжийн давхардлыг арилгах, хөтөлбөрүүдийн үр ашгийг дээшлүүлэх, улсын төсөвт үзүүлэх ачааллыг бууруулахад үзүүлэх үр нөлөөг үнэлэх үр дүнтэй механизмтай болох шаардлагатай.

**Нэмэлт тэтгэврийн сангийн эрх зүйн болон институцийн орчинг нэвтрүүлэх.** Энэ нь санхүүгийн хувьд тогтворгүй байгаа нийгмийн даатгалын тогтолцоог нөхөхөд шаардлагатай юм.

**Боловсрол, эрүүл мэндийн чанарыг сайжруулах.** Боловсролын болон эрүүл мэндийн салбарын чадавхийг сайжруулж бэхжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь энэхүү хоёр салбарын чанарыг сайжруулах, мөн алслагдсан хөдөө орон нутагт боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг хангахад нэн чухал үүрэг гүйцэтгэнэ. Ирээдүйн ажиллах хүчний шаардлагад нийцүүлэн сургуулийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх хэрэгтэй.

**Эрүүл амьдралын хэв маягийг сурталчлах.** Үүнийг олон нийтийн аян болон сургуулийн хөтөлбөрийн хүрээнд хийж болно. Эдгээр аргууд нь Монгол Улсад нийтлэг байгаа таргалалт, зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэхэд үр дүнтэй юм.

# Ашигласан материал

- Aizenman, J., Y. Jinjarak, H. T. K. Nguyen, and D. Park. 2019. Fiscal Space and Government-Spending and Tax-Rate Cyclicity Patterns: A Cross-Country Comparison, 1960– 2016. *Journal of Macroeconomics*. 60 (C). pp. 229–52.
- Akaha, T. 2004. Cross-Border Migration as a New Element of International Relations in Northeast Asia: A Boon to Regionalism or a New Source of Friction? *Asian Perspective*. 28 (2). pp. 101–133.
- Alfaro, L. 2003. Foreign Direct Investment and Growth: Does the Sector Matter? Unpublished manuscript. Boston, MA: Harvard Business School.
- Alfaro, L., and A. Charlton. 2007. Growth and the Quality of Foreign Direct Investment: Is All FDI Equal. *HBS Finance Working Paper*. No. 07-072. Cambridge, MA: Harvard University.
- Alгаа, S. 2013. Impact of Out-Migration to Korea: Macro and Micro-Level Consequences in Mongolia. *Journal of Multicultural Society*. 4(1). pp. 32–75.
